

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2015 оны 11 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Газрын тосны газрын 2013-2014 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын ажлын тайлан

1. Ерөнхий зүйл

Уул уурхайн сайдын 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 194 дүгээр тушаалын дагуу 2015 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн ажлын 43 хоногийн хугацаанд Газрын тосны газрын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд дотоод аудит хийлээ. Үүнд:

2.1. Салбарын хууль, эрх зүйн чиглэлээр

2.1.1. Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам, Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд:

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ		
№	Хуулийн заалт	Хэрэгжилт
1	7.1.4 Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах;	-“Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын төслийг боловсруулан УУЯ-нд хүргүүлсэн. -“Газрын тосны бүртгэл, тооцооны журам”-ын төслийг УУЯ-нд хүргүүлсэн. -Монгол Улсын Засгийн газрын 2015.7.07-ны өдрийн 295 тоот тогтоолоор “Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам”-ыг баталсан.
2	7.1.8 Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, цуцлах эрхийг олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2015.4.20-ны өдрийн 162 тоот тогтоолоор “Увс I”, “Хэрлэн тохой XXVIII” талбайд, 2015.6.15-ны өдрийн 246 тоот тогтоолоор “Хар-Ус II” талбайд БХГ байгуулах эрх тус олгосон. Монгол Улсын Засгийн газрын 2015.7.20-ны өдрийн 300 тоот тогтоолоор “Номгон IX” талбайн БХГ-ний эрх, үүргийг шилжүүлсэн байна.
3	7.1.12 Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг батлах;	Монгол Улсын Засгийн газрын 2015.3.16-ны өдрийн 104 тоот тогтоолоор БХГ-ны загварыг баталсан.
4	7.1.13 Энэ хуулийн 11.2.17-д заасан гэрээний загварыг батлах.	2015.7.08-ны өдрийн 1-817 тоот албан бичгээр уг гэрээний төслийг хүргүүлсэн. УУЯ бусад яамдаас саналыг авч, 2015.10.14-ний УУЯ-ны сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна.
5	8.1.3 Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны	-“Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага”-ын ажлын хэсэг ОУ-ын

	тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах;	техникийн туслалцаа авахаар хүлээгдэж байна. -“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага” нь УУС-ын 2015.3.10-ны өдрийн 49 тоот тушаалаар батлагдсан. -“Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага”-ыг УУС-ын зөвлөлөөр хэлэлцүүлж, өгсөн шийдвэрийн дагуу 39 хүснэгт шинээр нэмж бэлэн болгосон. -УУС-ын 2014 оны 202 тоот тушаалаар батлагдсан “Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам”-ыг ХЗЯ 2014.10.15-нд нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын жагсаалтад бүртгэсэн тул хуулийн нэгдсэн www.legalinfo.mn болон яамны www.mm.gov.mn сайтад тавигдсан. - УУС-ын 2015.3.12-ны өдрийн 53 тоот тушаалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам” батлагдсан байна.
6	8.1.4 Хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах;	Газрын тосны хайгуулын “Эргэл XII” талбайд сонгон шалгаруулалт явуулсан.
7	8.1.8 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;	2 сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд эхний уулзалтыг хийсний дараа 12 аймгаас санал авахаар явуулсан ба одоогийн байдлаар 4 аймгаас санал ирүүлсэн байна.
8	8.1.9 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах;	Уг дүрмийн төслийг боловсруулан УУЯ-нд хүргүүлсэн байна.
9	8.1.10 Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох;	УУС-ын 2015.3.12-ны өдрийн 53 тоот тушаалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам” батлагдсан.
10	9.1.1 Газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;	Газрын тосны хуулийг сурталчлан Төв, Дундговь, Өмнөговь, Дорнод, Говьсүмбэр, Дорноговь, Увс аймгуудын орон нутгийн уулзалтууд хийгдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2015.4.20-ны өдрийн 162 тоот тогтоолоор “Увс I”, “Хэрлэн тохой XXVIII” талбайд, 2015.6.15-ны өдрийн 246 тоот тогтоолоор “Хар-Ус II” талбайд БХГ байгуулах эрх тус тус олгосны дагуу дээрх гэрээнүүдийг байгуулсан.
	9.1.2 Хайгуулын талбайд	2015.5.04-ний өдөр газрын тосны хайгуулын Увс-1

11	захиалгахүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, энэ хуулийн 7.1.8-дзаасны дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах;	талбайд “Монголиа Гладвилл Увс Петролеум” ХХК-тай , 2015.5.21-ний өдөр газрын тосны хайгуулын Хэрлэн тохой ХХVIII талбайд “Хонконг Вэлпэк Индастриал” ХХК-тай, 2015.7.05-ний өдөр газрын тосны хайгуулын “Хар-Ус II” талбайд “Ренова-Илч” ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ тус тус байгуулж гарын үсэг зурсан байна.
12	9.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрх, үүргээ биелүүлэхтэй нь холбогдсон асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх;	ГТТХ-ийн шинэчилсэн найруулга, шинэчлэгдэн батлагдсан БХГ-ний загвар болон дагалдан гарсан журмуудын талаар гэрээлэгч компаниудтай уулзалт, ярилцлагыг 2-3 удаа зохион байгуулж, холбогдох зөвлөгөөг тогтмол өгдөг.
13	9.1.19 Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах стандарт, дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;	Хууль болон дагалдан гарсан журмуудын хэрэгжилтэд Гэрээлэлт, эрх зүйн хэлтэс нь холбогдох мэргэжлийн хэлтсүүдтэй хамтран хяналт тавин ажилладаг.
14	9.1.20 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааг хуульд заасан үндэслэлээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох, тус шийдвэрээ төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдсэн байх;	Хайгуул, судалгааны хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хуульд заасан үндэслэлээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох талаар хууль зүйн санал, дүгнэлт гарган ажилладаг.
15	10.2.1Төрийнзахиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тосны хайгуул явуулах талбайг зарлах тухай мэдэгдлийг хэлэлцэн дүгнэлт гаргах;	-“Бүтээгдэхүүн хуваах гэрээт-97”, Буйр ХХII талбайн талаар Дорнод,Дорноговь аймгийн засаг дарга нарт 2015.5.14-ний өдрийн 1-610,1-611 албан тоотоор мэдэгдэл хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй. -“Шарга-III” талбайд Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын ИТХ болон засаг дарга нарт 2015.9.22-ны өдрийн 1-1058-1063 тоотуудаар мэдэгдэл хүргүүлсэн. -“Нэмэгт-VI” талбайд Баянхонгор, Өвөрхангай,Өмнөговь аймгуудын ИТХ болон засаг дарга нарт 2015.9.22-ны өдрийн 1-1052-1057 тоотуудаар мэдэгдэл хүргүүлсэн байна.
16	11.2.17 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах	2015.7.08-ны өдрийн 1-817 тоот албан бичгээр уг гэрээний төслийг хүргүүлсэн. УУЯ бусад яамдаас саналыг авч, 2015.10.14-ний УУЯ-ны сайдын зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.
	15.1 Газрын тос, уламжлалт	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн

17	бус газрын тосны эрлийн ажлыг хуулийн этгээд төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэнэ.	гэрээг 16 ХХК-тай байгуулан ажиллаж байна.
18	19.1.1 Төрийн захиргааны байгууллага улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн болон төрийн захиргааны байгууллагаас ялгасан талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлана:	Уул уурхайн сайдын 2015.3.23-ны өдрийн 1/668 тоот албан бичгээр хэсэгчлэн буцаагдсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээт-97” Буйр ХХИ, 2015.9.04-ны өдрийн 195 тоот тушаалаар “Шарга-III”, “Нэмэгт- VI” талбайнуудыг дахин зарлах, нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаар чиглэл ирүүлсний дагуу бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа.

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ		
№	Хуулийн заалт	Хэрэгжилт
1	6.1.2 Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалахтай холбоотой стандарт, дүрэм, журам, нормын төслийг боловсруулах;	ГОСТ3122 “Цетаны тоо тодорхойлох, ASTM D 2211 “Бензины агуулга стандартуудыг орчуулж, холбогдох байгууллагуудаас санал авч СХЗТ-ийн Техникийн хороогоор хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна. “Нефть, нефтийн бүтээгдэхүүн савлах, хадгалах, тээвэрлэх” MNS362983 стандартыг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч байна.
2	6.1.3 Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, түгээх станц барьж байгуулах, шинэчлэх зураг төсөлд техник, технологийн талаар дүгнэлт гаргах;	Зураг төсөлд техник, технологийн дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй байна.
3	6.1.4 Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход мэргэжлийн дүгнэлт гаргах;	Хүсэлт ирүүлээгүй байна.
4	6.1.5 Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	2015 онд 3 ШТС, 2 АХЦС, 1 хий цэнэглэх станц /агуулах/-ыг байнгын ашиглалтанд хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд ажилласан байна.
5	6.1.6 Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;	Монгол Улсад импортолсон нийт газрын тосны бүтээгдэхүүний тоо хэмжээг ГЕГ-аас авч нэгтгэн боловсруулж, сар бүр удирлагад танилцуулж байна. Монгол Улсад импортолж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, нөөц, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүр авч нэгтгэн УУЯ, ТЕГ, ҮАБЗ-дхүргүүлдэг.
	6.1.7 Газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд шударга өрсөлдөх	Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд шударга нөхцлийг бүрдүүлэх үүднээс

6	<p>нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 14.1.5-д заасны дагуу холбогдох байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх, энэ талаар санал гаргах;</p>	<p>импортолж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, нөөц, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүр авч нэгтгэн боловсруулж ШӨХТГ-т хүргүүлж байна. Олон нийтийн хэрэгслэлээр бас мэдээлж байгаа болно.</p>
7	<p>6.1.8 Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах талаар сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх;</p>	<p>Импортлогч компаниудыг байнга мэдээллээр хангаж ажилладаг. Холбогдох асуудлаар эрх зүйн болон мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөгөө өгч байна.</p>
8	<p>6.1.9 Газрын тосны бүтээгдэхүүний олон улсын биржийн үнийг судлах, импортлогчийн нийлүүлэгчээс худалдан авах үнийг хянах.</p>	<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Платц” агентлагийн мэдээллийг авч боловсруулан ОХУ-ыг Европ, Азид экспортлох бүтээгдэхүүний төлөвлөгөө, томоохон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний үнэ зэрэг чухал шаардлагатай мэдээллүүдийг авч удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна.</p>
9	<p>13 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний нөөц</p> <p>Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь улсын болон компанийн нөөцөөс бүрдэнэ. Улсын нөөцийг Засгийн газраас баталсан журмын дагуу бүрдүүлнэ. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу компанийн нөөцийг бүрдүүлнэ.</p>	<p>Өнөөдрийн байдлаар 12730,6 тн газрын тосны бүтээгдэхүүн улсын нөөцөд бүрдүүлээд байна. /ДТ-10191 тн, АИ-92 автобензин-2538,8 тн/ Засгийн газрын 2014 оны 303 дугаар тогтоолоор компанийн нөөцийн хэмжээг 83350 тн байхаар заасан ба уг тогтоолын дагуу 16 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, компанийн нөөцийн хэмжээг 83350 тн-оос бууруулахгүй байхаар барьж байна. 2016 онд бүрдүүлэх компанийн нөөцийн хэмжээг тогтоож, Засгийн газрын тогтоолын төслийг УУЯ-нд хүргүүлсэн байна.</p>

Газрын тосны тухай болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн талаар гаргасан дүгнэлт

1. Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1-т зааснаар аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь “Төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тосны хайгуул явуулах талбайг зарлах тухай мэдэгдлийг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэгтэй.

Энэхүү заалтын дагуу Газрын тосны газраас шинээр болон дахин зарлаж буй талбайнуудад дүгнэлт гаргуулахаар талбайн танилцуулгыг хавсаргасан албан бичгийг удаа дараа явуулж байгаа боловч орон нутгаас хариу ирүүлэдэггүй байна.

2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т “Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход мэргэжлийн дүгнэлт гаргах” гэж заасан

ба Газрын тосны бүтээгдэхүүний барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх нь Газрын тосны газарт байдаггүй учраас хяналт тавих, хамтран ажиллахад хүндрэл учруулдаг байна.

3. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах”, 6.1.9-д “газрын тосны бүтээгдэхүүний олон улсын биржийн үнийг судлах, импортлогчийн нийлүүлэгчээс худалдан авах үнийг хянах” гэж заасан ба Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний судалгааг гаргахад импортлогч компаниуд нь мэдээгээ шатахуун түгээх станц бүрээр, аймгуудаар гэх зэргээр нарийвчилсан байдлаар гаргаж өгдөггүй. Компаний нууцын зэрэглэлтэй байдаг. Мөн компани жижиглэнгийн үнээ гаргаж өгдөггүйг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгаж мэдээ, мэдээллийг тухай бүр үнэн зөв гаргуулж авах нь хэрэглээний судалгааны гаргах ажилд чухал хувь нэмэртэй юм.

4. Улсын нөөцийн шатахууныг нэмж бүрдүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй тул Засгийн газрын 302 дугаар тогтоолийн хэрэгжилт биелээгүй байна.

5. УУС-ын 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 229 дүгээр тушаалаар “Шатахууны эрсдэлийн нөөцийн тухай хуулийн төсөл боловсруулах” ажлын хэсэг байгуулагдан ажилласан боловч өнөөдрийг хүртэл хуулийн төсөл боловсруулаагүй байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт

2015 оны байдлаар Монгол улсын нутаг дэвсгэрт Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 2 компани 3 талбайд газрын тосны олборлолтын үйл ажиллагаа, 18 компани 21 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байна.

Үүнээс Увс I, Хар Ус II, Хэрлэн тохой XXVII, Номгон IX нэртэй 4 талбайд 2015 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан.

Нялга XVI талбайд үйл ажиллагаа явуулахад орон нутгийн эсэргүүцэлтэй тулгарсан учих хугацаагүй мораториум авах хүсэлтийг “Шейман” ХХК-аас гаргасан, Тариач XV, Цагаан-Элс XIII, Зүүнбаян XIV талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг тайлагнаж, гэрээ дүгнэх акт үйлдээгүй тул Газрын тосны газраас уг гэрээнүүдийг цуцлах талаар УУЯ-нд санал гаргасан байна.

БХГ-ний ерөнхий мэдээлэл

Д/д	ЗГ-аас тогтоолын дугаар	баталсан	Компанийн харьяалал	Компанийн нэр	Талбайн нэр, хэмжээ	Талбайн хэмжээ
1	1993.12.21 №239	1997.12.10	БНХАУ	“Петрочайна Дачин Тамсаг монгол” ХХК	Тосон-Уул XIX	10460 км ²
2	1996.8.09 №144		БНХАУ	“Петрочайна Дачин Тамсаг монгол” ХХК	Тамсаг XXI	11130 км ²
3	2010.12.08 № 316		МУ	“Магнай трейд”	Баянтүмэн XVII	7832 км ²
4	2009.07.29 № 235		Их Британий Каймэний Арал	“Сентрал Азиан Петролиум” Корпорэйшн Лимитэд” ХХК	Богд-IV	28999 км ²
5	2009.07.29 № 235		Их Британий Каймэний Арал	“Сентрал Азиан Петролиум” Корпорэйшн Лимитэд”	Онги-V	21150 км ²

			ХХК		
6	2009.07.29 № 237	МУ	“Сансрын геологи хайгуул” ХХК	Цайдам-XXVI	23503 км ²
7	2009.07.29 № 237	МУ	“Сансрын геологи хайгуул” ХХК	Төхөм-Х (хойд)	21836 км ²
8	2009.07.29 № 236	МУ	“MCS” ХХК	Борзон-VII	31430 км ²
9	2009.07.29 №238	БНХАУ	“NPI” ХХК	Хөх нуур-ХVIII	9861 км ²
10	1997.2.19 №47	БНХАУ	“Доншен газрын тос Монгол” ХХК	БХГ-97	5321 км ²
11	2009.05.20 №148	Швейцарь	“DWM petroleum AG” ХХК	Зүүнбаян-XIV	11593 км ²
12		Швейцарь	“DWM petroleum AG” ХХК	Цагаан-Элс-ХIII	11593 км ²
13	2012 оны 253	МУ	“Монголын алт” ХХК	Төхөм-Х (урд)	24706 км ²
14	2011.02.09 № 39	БНХАУ	Арехпро investment limited Co ltd	Дарьганга-ХХIV	17178 км ²
15	2006.7.19 №170	Их Британий Каймэний Арал	“Петро Матад” ХХК	Матад-ХХ	10343 км ²
16	2007.6.20 №148	Канад	“Шейман” ХХК	Нялга-ХVI	12607.9км ²
17	1997.3.07 №47	БНХАУ	“Голден сий петролеум” ХХК	Тариач-ХV	7799 км ²
18	2009.05.20 № 147	БНХАУ	“Зон хэн Юу тиан” ХХК	Галба-ХI	9769 км ²
19	2009.07.22 № 22	МУ	“Шунхлай Энержи”	Сулинхээр ХХIII	13576 км ²
20	2013 оны № 02	Австрали	“Вульф петролеум” ХХК	Сүхбаатар ХХVII	23047 км ²
21	2015.04.20 №162	БНХАУ Хонконг	“Монголия гладвилл увс петролеум” ХХК	Увс-I	19720 км ²
22	2015.6.25 №246	БНХАУ Хонконг	“Ренова-Илч” ХХК	Хар Ус-II	27409 км ²
23	2015.04.20 №162	БНХАУ Хонконг	“Хонгконг Вэлпэк Индастриал” ХХК	Хэрлэнтохой-ХХVIII	14280 км ²
24	2015.07.20 №300	Монгол	“Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК	Номгон-IX	29861 км ²
Нийт талбайн хэмжээ					405,004 км²

Гэрээлэгч компаниудыг хөрөнгө оруулагч улсаар нь авч үзвэл 18 гэрээлэгчийн Монгол Улсын хөрөнгө оруулалттай 8, БНХАУ-ын 6, Их Британий Каймэний Арал 1, Швейцарь 1, Австралийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 компани байна. Эзлэх хувиар тооцож үзвэл Монгол-44.4%, БНХАУ-33.3%, бусад улсын хөрөнгө оруулалттай-22.3% компани гэрээлэгчээр ажиллаж байна.

БХГ нь 25 зүйл, 5 хавсралттай. Газрын тосны газраас БХГ-ний хэрэгжилтийг хуанлийн жил бүрээр дүгнэж, хангалтгүй хэрэгжсэн гэрээний зүйл заалтыг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гэрээлэгчтэй хэлэлцэж, акт үйлддэг. Ингэхдээ БХГ-

ний хэрэгжилтийг үзүүлэлт, тоо хэмжээ, чанарын хувьд үнэлж болохуйц ач холбогдол бүхий заалтуудыг дараах үндсэн шалгуураар дүгнэдэг. Үүнд:

1. Наад захын ажил үүрэг буюу заавал гүйцэтгэх ажил, үүрэгт уялдуулан төлөвлөсөн хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл.

2. БХГ-ний дагуу төлөх төлбөрүүдийг төлсөн байдал. Үүнд:

- Байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялаг ашигласны төлбөр /роялти/. Гэрээлэгч борлуулалт хийсэн тухай бүрт роялти төлнө. Хийгдсэн БХГ-үүдэд роялти 0-13,6 хүртэл хувьтай байна.
- Гэрээт талбайн дэнчин.
- Сургалтын урамшуулал. Гэрээлэгч гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш жил бүр гэрээт жилийн эхнээс 30 хоногийн дотор сургалтын урамшууллыг ГТГ-т төлнө.
- Төлөөлөгчийн газар /Засгийн газар/ болонороннутгийгдэмжих үйлажиллагаа. 3. Гэрээтталбайнбуцаалт. Гэрээлэгч нь хайгуулын ажлын эхний үе шат /1 дэх жил/ дуусахад гэрээт талбайн 25-50 хувийг, хоёр дахь үе шат дуусахад үлдсэн хэсгийн 20-30 хувийг буцаан өгнө /өгч болно/.

БХГ-ний үндсэн нөхцлүүдийг авч үзвэл:

Нийт 24 БХГ-ний 67% буюу 14 гэрээ 10-аас дээш хувиар роялти төлөх нөхцөлтэй. 1993 онд Тосон-уул XIX талбайд байгуулсан БХГ роялти байхгүй.

Газрын тосны нөөц, олборлолтын төлөв, байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

	Хайгуулын талбай	Ашиглалтын талбайн хэмжээ /км ² /	ЭБМЗ-ийн дүгнэлт	ЭБЭХ-ний сайдын тушаал	Нөөц /сая тонн/	
					Баталгаат	Ашиглалтын баталгаат
1	Тосон-Уул XIX	650	2010.02.04 №06 2011.06.03 №06	2010.02.18 №41 2011.06.21 №148	179,08	20,17
2	1997 БХГ-т	209.2	2011.04.18 №03	2011.06.08 №137	26,05	2,07
3	Тамсаг XXI	239.5	2012.03.02 №01/12	2012.05.16 №97	127,509	21,018
Нийт		1098.7			332,64	43,258

1993 онд батлагдсан “Тосон-Уул XIX”, 1997 онд батлагдсан “БХГ-97” бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд нь Монгол Улсын Засгийн газарт оногдох хувь нэмэгдэх боломжгүй зохицуулалттай байна. Үүнд:

Газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул XIX, Тамсаг-XXI, БХГ-97 зэрэг талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр (роялти), бүтээгдэхүүн хуваалтын хэмжээг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

№	Бүтээгдэхүүн хуваах гэрээний нэр	Роялти %	Ашигт тос (Хуанлийн сарын хуваах тосны өдрийн дундаж хэмжээ) /баррель/
1.	Тосон уул-XIX талбайд байгуулсан БХГ	0	50000 баррелиас бага бол МУ-ын Засгийн газар 40 хувь, гэрээлэгч 60 хувийг, 50001-100000 бол МУ-ын Засгийн газар 50 хувь, гэрээлэгч 50 хувийг, 100001 их бол МУ-ын Засгийн газар 55 хувь, гэрээлэгч 45 хувийг тус тус эзэмшинэ.

2.	Тамсаг-XXI талбайд байгуулсан БХГ	7.5	50000 баррелиасбага бол МУ-ын Засгийн газарт 40 хувь, гэрээлэгч 60 хувийг, 50001-100000 бол МУ-ын Засгийн газар 50 хувь, гэрээлэгч 50 хувийг, 100001 их бол МУ-ын Засгийн газар 55 хувь, гэрээлэгч 45 хувийг тус тус эзэмшинэ.
3.	БХГ-97 талбайд байгуулсан БХГ	7.5	25000 баррелиасбага бол МУ-ын Засгийн газар 38.75 хувь, гэрээлэгч 61.25 хувь, 25001-50000 бол МУ-ын Засгийн газар 45 хувь, гэрээлэгч 55 хувь, 50000-100000 бол МУ-ын Засгийн газар 50 хувь, гэрээлэгч 50 хувийг тус тус эзэмшинэ.

1.2. Газрын тосны олборлолт явуулж буй “Тосон-Уул XIX” талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 50001 баррель буюу түүнээс дээш олборлосон нөхцөлд Засгийн газарт 50%, 1997 оны “БХГ-97”-д өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 20001 баррель буюу түүнээс дээш олборлосон нөхцөлд Засгийн газарт 45%, хайгуулын 2006 оны “Матад ХХ” гэрээнд өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 20001 баррель буюу түүнээс дээш олборлосон нөхцөлд Засгийн газарт 40% ногдохоор заасан байна.

1.3. Өнөөгийн байдлаар “Тосон-Уул XIX” талбайн өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 10000 орчим баррель, 1997 оны “БХГ-97”-д өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 2700 орчим баррель газрын тос олборлож, экспортолж байгаа нь Монголын талд ногдох ашигт тосны хэмжээ нь БХГ-д тусгагдсанаар нэмэгдэх боломжгүй зохицуулалт агуулсан байна.

2. Петро Чайна Дачин Тамсаг ХХК-ны “Тосон-Уул XIX” талбайн гэрээнд байгалийн нөхөн сэргээгдэшгүй нөөц ашигласны төлбөр буюу роялти төлөх нөхцөл тусгагдаагүй байна.

2.1. “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ний гэрээт Тамсаг-XXI, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-ийн гэрээт БХГ-97 зэрэг талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр болох роялтийг 7.5 хувиар байгуулсан бөгөөд харин Тосон-Уул XIX гэрээт талбайн БХГ-нд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр (роялти) байхгүй байна.

Тосон-Уул XIX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны Монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ компани Монголын Засгийн газарт төлнө” гэж заасан нь тодорхойгүй байна.

- “Тосон-Уул XIX” талбайд 2013 онд 4,131,324 баррель буюу 550,256 тонн тос олборлож, 3,890,777 баррель буюу 515,476 тонн тос экспортолсон, 2014 онд 4,639,738 баррель буюу 618,226 тонн тос олборлож, 4,264,751 баррель буюу 565,014 тонн тос экспортолсон байна.
- “Тамсаг XXI” талбайд 2013 онд 796,558 баррель буюу 106,095 тонн тос олборлож, 760,740 баррель буюу 105,406 тонн тос экспортолсон, 2014 онд 2,340,073 баррель буюу 311,802 тонн тос олборлож, 4,264,751 баррель буюу 565,014 тонн тос экспортолсон байна.
- “Доншен газрын тос” ХХК-ийн 1997 оны БХГ гэрээт талбайд 2013 онд 510.473 баррель буюу 71.495 тонн тос олборлож, 507,702 баррель буюу 71,107 тонн тос экспортолсон, 2014 онд 440,567 баррель буюу 61,704 тонн тос олборлож, 439,836 баррель буюу 61,591 тонн тос экспортолсон байна.



Дээрх олборлолт, экспортын хэмжээнээс харахад “Тосон-Уул XIX” талбайгаас олборлож, экспортолсон тос нь 1997 оны БХГэрээнээс жилд дунджаар 5 дахин их тос экспортолсон ч роялти төлөх нөхцөл гэрээнд тусгагдаагүй тул яаралтай роялти тооцох шаардлагатай байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний орлого

Газрын тосны тухай хуулийн 9.1.9 дүгээр заалт, 30, 31, 34.2 дугаар зүйлд заасны дагуу Бүтээгдэхүүнхуваахгэрээний дагуудоорхтөлбөрүүдийг Улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан. Үүнд:

1. Газрын тос борлуулсаны экспортын орлого
2. Тусгай зөвшөөрлийн төлбөр
3. Гарын үсэг зурсны урамшуулал
4. Эрх шилжүүлсэний орлого

Газрын тосны тухай хуулийн 34.3 дугаар заалтын дагуу дараах төлбөрийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ. Үүнд:

1. Сургалтын урамшуулал
2. Төлөөлөгчийн газрыг дэмжих сангийн орлого

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу компаниудын төлсөн төлбөрийг хүснэгтээр үзүүлбэл:

Олборлолт явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Доншен Газрын Тос” ХХК-ийн газрын тос борлуулсаны орлого:

/мянган ам.доллар/

Он	“Петро Чайна Дачин Тамсаг” ХХК	“Доншен газрын тос” ХХК	Нийт дүн
2013	147,467,795.5	16,810,377.6	164,278,173.1
2014	263,542,667.2	22,009,825.6	285,552,492.8
Нийтдүн	411,010,462.7	38,820,203.2	449,830,665.9

2. Тусгай зөвшөөрлийн төлбөр

/ам.доллар/

№	Компанийн нэр	2013он		2014 он		Нийт зөрүү
		Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь	Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь	
1	Петро Матад ХХК	103,432	103,432	103,432	-	-103,432
2	Петро Чайна Дачин Тамсаг ХХК	314,576	314,576	209,108	209,108	-
3	Доншен газрын тос ХХК	62,790	41,506	84,074	62,790	-42,568
4	Голдэн Сий петролиум ХХК	62,394	31,193	62,394	31,193	-31,197
5	Шейман ХХК	36,960	-	36,960	-	-72,920
6	DWM Petroleum ХХК /Гоби Энержи Партнерс/	34,912	12,072	34,883	22,840	-34,883
7	Зон Хэн Юу Тиан	39,077	39,077	39,077	39,077	-
8	Сентрал Азиан Петролеум корпорейшн лимитед ХХК	200,593	-	200,593	-	-401,186
9	Эн Пи Ай ХХК	39,444	39,444	21,104	21,104	-
10	Импайр газ ХХК	125,720	125,720	125,720	125,720	-

11	Сансрын геологи хайгуул ХХК	265.454	265,454	113.815	-	-113,815
12	Шунхлай энерги ХХК	54.300	-	108,600	108,600	-54,300
13	Алекспро инвестмент ХХК	34.360	34,360	68,720	68,720	-
14	Магнай Трейд ХХК	46.995	15,665	62.660	31,254	-62,736
15	МАК ХХК	49.412	49,412	49,412	-	-49,412
16	Вульфпетролиум	23.048	23,048	46,095	46,095	-
	Нийтдүн	1,493,466	1,094,958	1,366,645	766,500	-998,653

3. Гарын үсгийн урамшууллын орлого /ам.доллар/:

№	Компанийннэр	2013	2014	Нийтдүн
1	МагнайТрейд ХХК	-	-	-
2	МАК ХХК	-	-	-
3	Вульфпетролиум	200,000	-	200,000
	Нийт	200,000	-	200,000

4. Эрхшилжүүлсэнийорлого /ам.доллар/:

№	Компанийннэр	2013	2014	Нийтдүн
1	Импайр газ ХХК	-	20,000	20,000
2	Шунхлай энерги ХХК	-	100,000	100,000
	Нийтдүн	-	120,000	120,000

Газрын тосны хайгуулын талбайнуудад байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн хэрэгжилтийн талаар гаргасан дүгнэлт:

2014 онд нийт хайгуулын 18 талбайн БХГ-нээс Матад-ХХ, Галба XI, Хөхнуур XVIII, Сулинхээр XXIII, Богд IV, Онги V, Борзон VII, Баянтүмэн XVII, Сүхбаатар XXVII нийт 9 талбайн төлөвлөгөө, төсөв батлагдаж үйл ажиллагаа хэвийн явагдсан. Тариач XV, Нялга XVI, Төхөм X хойд, Цайдам XXVI, Дарьганга XXIV, Төхөм X урд, Номгон IX нийт 7 компанийн 9 талбайн төлөвлөгөө, төсөвбатлагдаагүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Төхөм X хойд, Цайдам XXVI, Төхөм X урд талбайнуудаас бусад талбайд байгуулсан гэрээнүүдийн дагуу төлөх төлбөр урамшуулал бүрэн төлөгдсөн.

2014 онд БХГ-ний дагуу хайгуулын үйл ажиллагаанд нийт 723 гадаадын ажиллах хүч ажиллах зөвшөөрөл авсанаас 500 гадаад ажилтан МУ-д ирж ажилласан байна. Үүнд: ЗонХэн Юу Тиан ХХК-214, Эн Пи Ай ХХК-225, Сансарын геологи хайгуул ХХК-61 ажилтан оруулж ирсэн байна.

1. 1997 оны БХГ-т талбайд байгуулсан БХГ нь 26 зүйл, 93 заалттай.

а/ Тус талбайн БХГ-ний хэрэгжилтийн тайланг 2014 онд Газрын тосны газраас БХГ-ний хэрэгжилт гаргах загвар боловсруулж, БХГ-ний 1993-2013 оны хэрэгжилтийг шинэ загварын дагуу дахин гаргасан.

- 7.2.а, б болон в заалтын хэрэгжилт хангалтгүй байна.¹

¹БХГ-ний 12 дугаар хуудас., Гэрээ ёсоор талбайг буцааж өгөх тухай зүйл

б/ БХГ-ний хэрэгжилтийн явцад дараах заалтуудын хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Газрын тосны тухай хуулийн 24.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл шинэчлэн авах,
- Хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хянаж, баталгаажуулах ажлыг түргэвчлэх,

2. Тамсаг-XXI талбайд байгуулсан БХГ нь 25 зүйл, 85 заалттай.

а/ 2013 онд Тус талбайн БХГ-ний хэрэгжилтийн тайланг баталсан шинэ загварын дагуу дахин гаргасан.

БХГ-ний хэрэгжилтийн явцад дараах заалтуудын хэрэгжилт хангалтгүй, цаг хугацаа баримталдаггүй дутагдлууд байна. Үүнд:

- БХГ-ний 5.5 заалт нь ГТТХХЖ-ын 12.1 дэх заалт хоорондоо хугацааны хувьд зөрүүтэй байна.²
- 7.2 а, б болон в заалтын хэрэгжилт хангалтгүй байна.^{1,2}

Гэрээлэгчийн 2011, 2012, 2013 онд газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтад санхүүгийн шалгалт хийгдэж дуусаагүй, өртөг нөхөгдөх зардлын хэмжээг тогтоож, баталгаажуулаагүй байна.

БХГ-ний хэрэгжилтийн явцад дараах заалтуудын хэрэгжилт хангалтгүй, дутагдалтай байгаа тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Газрын тосны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 24.2-т: “Гэрээлэгч ашиглалт эхлэхээс өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл авах бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс ашиглалтын хугацаа эхэлнэ” гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл шинэчлэн авах,
- Талбай буцаан авах тухай ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж, холбогдох сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх,
- Хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг хянаж баталгаажуулах ажлыг түргэвчлэх,
- 2014 оны сургалтын урамшууллын 5 ам.долларын дутуу төлөлтийг нөхөн төлүүлэх,
- 2015 онд тусгай зөвшөөрлийн төлбөрийг тооцохдоо Газрын тосны тухай хуулийн 30.2, 30.4 дэх заалтыг баримтлах,

3. Тосон-Уул XIX талбайд байгуулсан БХГ нь 25 зүйл, 88 заалттай.

а/ Тус талбайн БХГ-ний хэрэгжилтийн тайланг 2011, 2012 онд гаргаж байсан ба 2014 онд Газрын тосны газраас БХГ-ний хэрэгжилт гаргах загвар боловсруулж, БХГ-ний 1993-2012 оны хэрэгжилт, мөн 2013 оны хэрэгжилтийг шинэ загварын дагуу дахин гаргасан.

2011, 2012, 2013 оны санхүүгийн шалгалтын дүн гараагүй байгаа нь өртөг нөхөлтийн хэмжээг тогтоох боломжгүй байна.

БХГ-ний хэрэгжилтийн явцад дараах заалтуудын хэрэгжилт хангалтгүй байдалтай байна. Үүнд:

- БХГ-ний 5.5 заалт нь ГТТХХЖ-ын 12.1 дэх заалт хоорондоо хугацааны хувьд зөрүүтэй байна.
- 7.2.а, б болон в заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- 2011, 2012, 2013 оны хөрөнгө оруулалтад санхүүгийн шалгалт хийгдээгүйгээс өртөг нөхөгдөх зардлын хэмжээ баталгаажаагүй байна.
- Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн зүгээс Монгол улсын Засгийн газарт төлөх ёстой төлбөрийн **1 сая ам.долларыг** татварын зардал болгон дур мэдэн суутгасан байна.

²"Тамсаг XXI" талбайн БХГ-ний 12 дугаар хуудас., Олборлолтын хугацаа

4. Тариач-ХV талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Голден Сий Петролеум ХХК-ийн хувьд:

БХГ-ний 2014 оны хэрэгжилт гаргаагүй. Гэрээлэгчээс 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр гаргасан хайгуулын хугацааг 2014 оны 3 дугаар сарын 08-ны өдрөөс дахин сунгуулах тухай хүсэлтийг Хайгуул судалгааны хэлтэс судалж үзээд БХГ-ний дагуу төлбөр, урамшууллыг төлөх, өмнө сунгасан 2 жилд төлөвлөснөөс багагүй хайгуулын ажил хийх, байгаль орчны ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн тохиолдолд хугацаа сунгах асуудлыг хэлэлцэхийг мэдэгдсэн байна. 2014 оны 02 дугаар сарын 15-ны өдөр гэрээлэгч хайгуулын ажлын төлөвлөгөөг ирүүлсэн боловч байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй байна.

ГТГ-аас гэрээлэгчид тавьсан шаардлагыг биелүүлээгүй, санаачилга гаргаж ажиллаагүй тул 2014 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 1/795 албан тоотоор БХГ-г цуцалж, талбайг буцааж авах талаар мэдэгдсэн байна.

БХГ-г цуцлах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох яаманд /УУЯ/ 2015 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 1/591, 08.27-ны өдрийн 1-/956 тоот албан тоотуудыг Газрын тосны тухай хуулийн 13.1.1-13.1.6 дүгээр заалтуудад заасны дагуу гэрээний биелэлтийг дүгнэж, дүгнэлтийг УУЯ-нд хүргүүлсэн байна.

5. Нялга-ХVI талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Шэйман ХХК-ийн хувьд:

Тус компани нь БХГ-ний 2014 оны хэрэгжилт гаргаагүй. Шэйман ХХК нь 2007, 2010, 2012 онуудад гэрээт талбайд хэсэгчлэн хайгуул хийж, нийт 16,5 сая ам.долларыг хайгуулын үйл ажиллагаанд зарцуулсан. БХГ-нд заасан 2013-2015 онуудын төлбөр, урамшууллыг төлөөгүй. БХГ-ний хайгуулын үйл ажиллагаа найдвартай явуулах боломж нөхцлөөр хангах хүртэл хайгуулын хугацааг зогсоож, төлбөр, урамшууллыг төлөхгүй гэдгээ гэрээлэгч мэдэгдсэн байна.

Шэйман ХХК-иас Газрын тосны газарт 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 13/081 тоотоор орон нутгийн зүгээс хайгуул хийхийг зөвшөөрөх хүртэл хайгуулын хугацааг зогсоох хүсэлт гаргасныг Засгийн газраар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр УУЯ-нд 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1/1371, 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 1/1445, 2015 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 1/956 тоотуудаар уламжилсан байна.

УУЯ-аас өгсөн чиглэлийн дагуу 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Хэнтий аймагт орон нутгийн уулзалт зохион байгуулж, гэрээлэгчийн орон нутагт үүссэн асуудлыг ярилцсан байна.

6. Цагаан Элс-ХIII, Зүүнбаян-ХIV талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Гоби энержи партнерс ХХК-ийн хувьд:

Тус компани нь БХГ-ний 2014 оны хэрэгжилтийг гаргаагүй. 2 талбайд 2009-2012 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнгээр үр цаашид хайгуулын ажил хийх шаардлагагүй гэж дүгнэн, гэрээт талбайн 80 гаруй хувийг буцаасан байна. Үлдсэн талбайн хэмжээнд (3010.8 км²) тогтоосон бүтэц нь 1997БХГ-т талбайгаас буцаасан хэсэгт үргэлжилж байгааг тул цаашид энэ хэсэгт хайгуул хийх хүсэлтийг Газрын тосны газарт 2012 оны 12 дугаар сард гаргасныг УУЯ-нд уламжилсан байна. Үүний дагуу УУЯ-аас 1997БХГ-т талбайн буцаасан хэсэгт шинээр БХГ байгуулах гэрээлэгчийг сонгон шалгаруулах чиглэл өгсөн тул Газрын тосын тухай хуулийн дагуу талбайг нээлттэй зарлах талаар орон нутгаас лавлагаа

авахаар 2015 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 1/376, 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 1/610 албан тоотуудыг тус тус хүргүүлсэн боловч орон нутгаас хуулийн хугацаанд хариу ирүүлээгүй тул талбайг нээлттэй зарлах болсныг 2015 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 1/947 албан тоотоор орон нутагт мэдэгдсэн байна.

Гэрээлэгч 2013 онд 1 жилийн мораториум авсан. БХГ-нд заасан 2013-2015 оны төлбөр, урамшууллыг төлөөгүй, мөн 2013, 2014, 2015 онд ажил хийгээгүй байна.

ГТГ-аас 2 талбайн БХГ-г цуцлах саналыг УУЯ-нд гаргахаар бэлтгэж байгаа юм байна.

7. Төхөм -Х (хойд), Цайдам –XXVI талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Сансарын геологи хайгуул ХХК-ийн хувьд:

Сансарын геологи хайгуул ХХК нь БХГ-нд заасан 2014 оны төлбөр урамшууллыг төлөөгүй, хайгуулын ажил хийгээгүй, төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй байна.

2012 оны төлөвлөгөөнд тусгагдсан байсан 26-001 дугаартай цооногийг 2014 оны 5 дугаар сарын 16-31-ний хооронд 1402.30 метр хүртэл өрөмдсөн ба үр дүн нь хуурай гарсан.

ГТГ-аас гэрээлэгчид хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулах, хайгуулын ажлаа хийх, төлбөр, урамшууллыг төлөхийг 2014 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 5/623, 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 1/708, 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/1161, 2015 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 1/305, 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 1/499 тоотуудаар мэдэгдсэн боловч гэрээлэгчийн зүгээс холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй тул БХГ-г цуцлах тухай мэдэгдлийг гэрээлэгчид 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлсэн байна.

Сансарын геологи хайгуул ХХК-ийн хөрөнгө оруулагч Одод ХХК “Хувьцаа худалдах, худалдан авах” гэрээгээр хувьцаагаа 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Эн Пи Ай ХХК-д худалдсанаар Сансарын геологи хайгуул ХХК-ийн хөрөнгө оруулагч нь Эн Пи Ай ХХК болсон.

Эн Пи Ай ХХК нь газрын тосны хайгуулын Хөхнуур XVIII талбайн БХГ-ний гэрээлэгч бөгөөд Хөхнуур XVIII талбайгаас туршилтын үед тос илэрсэн нь Төхөм Х_{хойд}, Цайдам XXVI талбайнуудад санхүүгийн эх үүсвэр олох магадлалыг нэмэгдүүлж байгаа тул гэрээ цуцлах асуудлыг түр хугацаагаар хойшлуулах хүсэлт тавьсан байна.

8. Дарьганга XXIV талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Апекспро инвестмент лимитед ХХК-ийн хувьд:

2014 оны БХГ-ний хэрэгжилтийг заалт бүрээр гаргаж баталгаажуулсан байна. БХГ-ний дагуу төлбөр, урамшууллыг бүрэн төлсөн боловч хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулаагүй.

ГТГ-аас 2014 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 1/433, 2014 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 5/623, 2014 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 1/974, 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/1164 тоотуудаар төлөвлөгөө, төсвийг батлуулах, хайгуулын ажлаа эхлүүлэхийг, 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 14/26 тоотоор 2013, 2014 онуудад хийгээгүй доод хэмжээний ажлыг 2015 онд хийж гүйцэтгэх тухай мэдэгдсэн боловч хариу ирүүлээгүй байгаа юм байна.

9. Төхөм -Х (урд) талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Монголын алт ХХК-ийн хувьд:

БХГ-ний 2014 оны хэрэгжилтийг заалт бүрээр гаргаж баталгаажуулсан боловч БХГ-ний дагуу 2013, 2014 оны төлбөр, урамшууллыг төлөөгүй. ГТГ-аас 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/1166 тоотой хайгуулын ажлыг эхлүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн байна. 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/1560 албан тоотой 2014 оны хайгуулын ажлыг 2015 онд хийж гүйцэтгэх хүсэлт тавьсан хэдий ч 2015 оны хайгуулын ажлын төлөвлөгөө төсвийг батлуулаагүй байна. ГТГ-аас БХГ-ний хэрэгжилт хангалтгүй, төлбөр, урамшууллыг төлөөгүй үндэслэлээр БХГ-г цуцлах саналыг холбогдох яаманд гаргасан байна.

2.1.2 Газрын тосны газраас гаргасан тушаал, шийдвэр тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд:

1. **Газрын тосны газрын даргын 2009 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай” тушаал нь Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргалаа.**

1.1. Газрын тосны газрын даргын 2009 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай” тушаалын 8.8.3 дахь хэсэгт заасан “Үр дүнгийн гэрээг дүгнэж өгсөн үнэлгээгээр 90-100 оноо буюу “маш сайн” үнэлгээ авсан авсан ажилтныг **албан тушаалын жилийн цалингийн 30-40 хувьтай тэнцэх** хэмжээний, 80-89 оноо буюу “сайн” үнэлгээ авсан ажилтныг албан тушаалын жилийн цалингийн 20-30 хувьтай тэнцэх хэмжээний, 70-79 оноо буюу “хангалттай” үнэлгээ авсан авсан ажилтныг албан тушаалын жилийн цалингийн 10-20 хувьтай тэнцэх хэмжээний үр дүнгийн шагналыг ЗСХ-05 маягтын дагуу гаргасан тодорхойлолтын дагуу Газрын даргын тушаалаар олгоно” гэсэн заалт нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 5-д “Төрийн байгууллагын захиргаа нь мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай сайн биелүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байгаа төрийн албан хаагчид улирлын ажлын нь үр дүнгээр **албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай** тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно. Албан хаагчийг тийнхүү шагнаж урамшуулах үзүүлэлт, журмыг төрийн тухайн байгууллага боловсруулж хэрэгжүүлнэ” заасныг зөрчсөн байна.

1.2. Тус журмын 8.10 дахь хэсэгт “Энэхүү журмын 8.7, 8.8.3-т заасан нэмэгдэл хөлс, шагналт цалин олгох журмыг Газрын дарга тогтооно” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3-т “Төрийн албан хаагчийг энэ зүйлийн 31.1.1, 31.1.2-т заасан шагналаар шагнах болон мөн зүйлийн 31.2-т заасан мөнгөн урамшил олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар, энэ зүйлийн 31.1.3-т зааснаар шагналд тодорхойлох журмыг хуулиар тус тус тогтооно, мөн ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 5-д “Төрийн байгууллагын захиргаа нь мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай сайн биелүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байгаа төрийн албан хаагчид улирлын ажлын нь үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн

40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно” заасныг тус тус зөрчсөн байна.

1.3. Тус журмын 8.11.5-д “Төрийн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтанд 50, 60 насны ойгоор нь 100,000 /зуун мянга/ хүртэлх төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгах” гэж заасан нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 6-д “Төрийн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, олон жил (10-аас доошгүй жил) ажилласан төрийн албан хаагчид насны ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан болон гэр бүл болоход нь байгууллагын захиргаанаас 50,000 хүртэл төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг дурсгаж болно” гэснийг зөрчсөн байна.

2. Газрын тосны газрын даргын 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай” 08 дугаар тушаал нь Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргалаа.

2.1. 6.9.6 дахь заалтад “Ажилтан шинээр гэр бүл болох, хүүхэдтэй болох зэрэг баярт үйл явдлыг тохиолдуулан 200,000 төгрөгийн тусламж олгох” гэж заасан нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 6-д “Төрийн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, олон жил (10-аас доошгүй жил) ажилласан төрийн албан хаагчид насны ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан болон гэр бүл болоход нь байгууллагын захиргаанаас 50,000 хүртэл төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг дурсгаж болно” гэснийг зөрчсөн байна.

3. ГТГ-ын даргын 2013-2015 онуудад батлан гаргасан боловсон хүчин болон үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалууд холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргалаа. Үүнд:

- 3.1. 2013 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Гэр бүлийг дэмжих тухай” 30 дугаар тушаалаар ҮТХ-ийн орон нутаг дахь төлөөлөгч Д.Гийх-Одмаа нь хүүхэдтэй болсонд нь баяр хүргэж 100,000 төгрөг;
- 3.2. 2013 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн “Гэр бүлийг дэмжих тухай” 78 дугаар тушаалаар АОХ-ийн дарга Ч.Жамсран хүүхэдтэй болсонд нь баяр хүргэж 100,000 төгрөг;
- 3.3. 2013 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн “Гэр бүлийг дэмжих тухай” 96 дугаар тушаалаар ҮТТХ-ийн мэргэжилтэн П.Давааням хүүхэдтэй болсонд баяр хүргэж 100,000 төгрөг;
- 3.4. 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Гэр бүлийг дэмжих тухай” 189 дугаар тушаалаар ХСХ-ийн мэргэжилтэн Р.Наранбаатарын гэр бүл охинтой болсонд баяр хүргэж 100,000 төгрөг;
- 3.5. 2014 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 72 дугаар тушаалаар мэргэжилтэн Н.Дарханбаярын гэр бүл хүүхэдтэй болсонд баяр хүргэж 200,000 төгрөг;
- 3.6. 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн “Буцалтгүй тусламж олгох тухай” 45 дугаар тушаалаар АОХ-ийн мэргэжилтэн Ц.Алтантулгын гэр бүл охинтой болсонд баяр хүргэж 200,000 төгрөг;
- 3.7. 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн “Гэр бүлийг дэмжих тухай” 154 дугаар тушаалаар ҮТТХ-ийн мэргэжилтэн Д.Цэнд-Аюушт хүүхэдтэй болсонд нь баяр хүргэж 200,000 төгрөг;

- 3.8. 2014 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 183 дугаар тушаалаар мэргэжилтэн Б.Энхзаяа хүүхэдтэй болсонд баяр хүргэж 200,000 төгрөг;
- 3.9. 2014 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 183 дугаар тушаалаар Дархан дахь төлөөлөгч Э.Азжаргал гэр бүл болж байгаад баяр хүргэж 200,000 төгрөг;
- 4.1. 2014 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн “Баяр хүргэх тухай” 160 дугаар тушаалаар Архив бичиг хэргийн эрхлэгч Л.Оюунгэрэл, ГТБХХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Наранхүү, Дорнод дахь төлөөлөгч Д.Гантуяа, Сэлэнгэ дэх төлөөлөгч Д.Аззаяа, ҮТТХ-ийн а/мэргэжилтэн С.Энхбат нар 50 нас хүрсэн тул баяр хүргэж тус тус 100,000 төгрөг, нийт 500,000 төгрөг;
- 4.2. 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 29 дүгээр тушаалаар Ашиглалт, олборлолтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Алтангарал 60 нас, Хайгуул судалгааны хэлтсийн дарга О.Энхбаяр, Техник, үйлчилгээний төвийн жолооч Н.Цогтдэмбэрэл нар нь 50 нас хүрсэн тул баяр хүргэж, тус бүр 100,000 төгрөг, нийт 300,000 төгрөгөөр;
- 4.3. 2013 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 168 дугаар тушаалаар Н.Батсайхан, Л.Басан, үйлчлэгч Ц.Алтанцэцэг нар 50 нас хүрсэнд баяр хүргэж, тус бүр 100,000 төгрөг, нийт 300,000 төгрөгөөр;
- 4.4. 2013 оны 11дүгээр сарын 07-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 191дүгээр тушаалаар мэргэжилтэн Ц.Төгс нь 50 нас хүрсэн тул баяр хүргэж 100,000;
- 4.5. 2014 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 63 дугаар тушаалаар жолооч Б.Чинбат нь 50 нас хүрсэн тул баяр хүргэж 100.000 төгрөгөөр;
- 4.6. 2013 оны 11дүгээр сарын 12-ны өдрийн “Баяр хүргэх тухай” 195дугаар тушаалаар ХСХ-ийн а/мэргэжилтэн Ц.Оюундарь 50 нас хүрсэн тул баяр хүргэж 100,000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 6-д: “Төрийн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, олон жил (10-аас доошгүй жил) ажилласан төрийн албан хаагчид насны ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан болон гэр бүл болоход нь байгууллагын захиргаанаас 50000 хүртэл төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг дурсгаж болно” гэснийг зөрчиж илүү мөнгөн урамшуулал олгосон байна.
- 5.1. 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Тусламж олгох тухай” 205 дугаар тушаалаар АОХ-ийн төлөөлөгч Ч.Жаргалсайханы хүү гэр бүл болж байгаад баяр хүргэн 200,000 төгрөг;
- 5.2. 2014 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн “Буцалтгүй тусламж олгох тухай” 228 дугаар тушаалаар АОХ-ийн а/мэргэжилтэн Л.Алтангэрэлийн хүү гэр бүл болж байгаад баяр хүргэн 200,000 төгрөг;
- 5.3. 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн “Тусламж олгох тухай” 140 дүгээр тушаалаар ГТГ-ын дарга Г.Өлзийбүрэнгийн хүү, АОХ-ийн мэргэжилтэн Ө.Батбаярын охин гэр бүл болж байгаад баяр хүргэн гэр бүлийг нь дэмжиж, тус бүр 100,000, нийт 200,000 төгрөгийн тусламж олгосон нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоол болон ГТГ-ын даргын 2015.01.15-ны өдрийн 08 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 6.9.6-д “Ажилтан шинээр гэр бүл болох, хүүхэдтэй болох зэрэг баярт үйл явдлыг тохиолдуулан 200,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгох” гэж заасан ба ажилтны хүүхдэд олгох талаар заагаагүй байна.

- 6.1. 2014 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн “Нэг удаагийн нэмэгдэл цалин олгох тухай” 77 дугаар тушаалаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогын эхний 4 сарын төлөвлөгөөг ханган биелүүлэх нөхцөл бүрдсэнийг харгалзан агентлагийн нийт ажилтнуудад албан тушаалын 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэмэгдэл цалин;
- 6.2. 2013 оны 11дүгээр сарын 08-ны өдрийн “Нэг удаагийн нэмэгдэл цалин олгох тухай” 192дугаар тушаалаар 2013 оны тодотгосон төлөвлөгөөг ханган биелүүлэх нөхцөл бүрдсэнийг харгалзан нийт ажилтнуудад албан тушаалын үндсэн цалингийн 1 сарын цалин хүртэлх хэмжээгээр 1 удаагийн нэмэгдэл цалин олгосон нь: Монгол Улсын Их Хурлын 2012 оны “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 ондхэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 37 дугаар тогтоолын хавсралтад: цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлэх; цалин, тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмэх үйл ажиллагааг **Засгийн газраас хэрэгжүүлнэ** гэж тогтоосныг зөрчсөн байна.
- 6.3. 2013 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” 80 дугаар тушаалаар ГТСалбар үүсч хөгжсөний 72 жилийн ойг тохиолдуулан нийт ажилтнуудыг нэг сарын үндсэн цалинтай тэнцүү хэмжээний /нийт 49,770,106 /урамшуулал;
- 6.4. 2014 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” 116 дугаар тушаалаар ГТ-ны салбар үүсч хөгжсөний 73 жилийн ойг тохиолдуулан нийт ажилтнуудыг нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний /нийт 52,968,321/ урамшуулал олгосон;
- 6.5. 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Гадаад томилолтоор ажиллуулах тухай” 85 дугаар тушаалаар Газрын тосны салбар үүсч хөгжсөний 73 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд нийт албан хаагчдын 13-16 насны 14 хүүхдийг Япон улсад 8 хоногийн хугацаатай нийт 20,816,000 төгрөг, 3780 ам.доллар, 2,032,000 иенээр төсвийн гадаад томилолтын зардлаас санхүүжүүлэн аялуулсан байна.

7.1. 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 227 дугаар тушаалаар Ахмадуудыг 3,256,600, ГТГ-ын ажилтнуудыг 4,216,000, нийт 7,472,600 төгрөгөөр өдрийн амралтанд амраасан байна.

Тус тушаал нь “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн 8.5 дахь хэсэгт : Энэ хуулийн 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан төсөвт байгууллага үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, аж ахуйн нэгж, байгууллага үлдэгдэл ашгаас цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулна, 8.4: Аж ахуйн нэгж, байгууллага ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын 9.5-д “Газрын ахмадын хороонд бүртгэлтэй ахмад настнуудад жил бүрийн билгийн тооллын хаврын тэргүүн сар цагаан сарын баяр болон ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах, түүнчлэн тэдний амьдрал ахуйд гачигдал тохиолдсон нөхцөлд зохих тусламж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна” гэсэн заалтуудыг үндэслэсэн байна. Дээрх хууль болон журамд амрах талаар заагаагүй байх бөгөөд ГТГ-ын албан хаагчид мөн хамрагдсан байна.

- 8.1. 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Оюутнуудыг шагнах тухай” 232 дугаар тушаалаар 2013-2014 оны хичээлийн жилд сурлагын амжилтаар тэргүүлсэн оюутан Сандаг-Очирын Хандмаа, Гылымханы Жандаулет, Батбаатарын Эрдэнэсүх, Бямбадалайн Билгүүн, Ганболдын Тэргэл нарыг тус тус 1000 юан, нийт 5000 юанаар;
- 8.2. 2013 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” 222 дугаар тушаалаар Сургалтын урт хугацааны гэрээ байгуулж Бээжин хотод ГТосны Их сургуульд суралцаж буй оюутнуудаас БНХАУ-ын хэмжээнд гадаад оюутнуудын дунд зохион байгуулагдсан хятад хэлний уралдаанд тэргүүн байр эзэлсэн Ч.Золбоо, сургуулийн тэргүүний оюутан болж өндөр амжилт гаргасан Б.Эрдэнэсүх, Г.Тэргэл, Ц.Ариунболд, Оюутны зөвлөлийн зохицуулагчийн урамшуулал Б.Эрдэнэсүх нарт нийт 1,350,000 төгрөгийн урамшууллыг сургалтын данснаас шагнасан байна. ЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан “БХГ-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам”-ын 8 дугаар зүйлд заасан Суралцагчид олгох тэтгэлэг, тэтгэмжийн зардалд шагнаж, урамшуулах талаар заагаагүй байна.
- 9.1. 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “Шагнах тухай” 132 дугаар тушаалаар газрын тосны эрэл хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах мөн газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн үнэ болон хангалтыг тогтвортой байлгаж, иргэдийн амжиргааг сайжруулж улсын эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан ХСХ-ийн дарга **О.Энхбаяр**, ГТБХХ-ийн даргаар ажиллаж байсан **Л.Раднаасүрэн**, а/мэргэжилтэн **Э.Халиун**, а/мэргэжилтэн **Ц.Төгс**, ЭЗСХОХ-ийн а/мэргэжилтэн **Х.Бямбадорж**, Техник үйлчилгээний төвийн дарга **Г.Төмөрбаатар** нарыг тус тус 5 сая, нийт 30 сая төгрөгийг сургалтын сангийг хөрөнгөөс гаргасан нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйл, ЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолын 9.3-т: “Сургалтын дансны хөрөнгийг энэ журамд зааснаас бусад зориулалтаар захиран зарцуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.
- 10.1. 2014 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 163 дугаар тушаалаар Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийг салбарын хэмжээнд сурталчилах, хуулийг дагалдан гарах журмуудын талаар УИХ-ын гишүүд болон УУЯ-ны холбогдох хүмүүст сурталчилахад Ажлын хэсэгт шаардагдах 7,775,000 төгрөгийг сургалтын зардлаас гаргасан нь ЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолын 9.3-т: “Сургалтын дансны хөрөнгийг энэ журамд зааснаас бусад зориулалтаар захиран зарцуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.
- 11.1. 2013 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн “Ажилд томилох тухай” 101 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

Д/д	Овог нэр	Үндсэн цалин	Хавсран %	Удаан жил	Ур чадвар	Зэрэг %	Мэргэшсэн%	Нийт нэмэгдэл
1	Л.Оюунгэрэл	526,642	30	0	25	0	15	70
2	Г.Төмөрбаатар	660,752	30	0	25	0	15	70
3	Б.Оюун	692,117	20	25	0	28	15	88

- 11.2. 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Ажилтнуудын цалинг шинэчлэн тогтоох тухай” 206 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АНГИЛАЛД ХАМРАГДАХ АЖИЛТНУУДЫН ЦАЛИН

Д/д	Албан тушаал	Овог нэр	Үндсэн цалин	Хавсран %	Удаан жил	Зэрэг %	Мэргэшсэн%	Нийт нэмэгдэл
1	Сургалт хариуцсан а/мэргэжилтэн	Ш.Уранчимэг	733,863	30	20	22		72
2	Ерөнхий санхүүч	Б.Оюун	795,935	20	25	28	15	88

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛД ХАМРАГДАХ АЖИЛТНУУДЫН ЦАЛИН

Д/д	Албан тушаал	Овог нэр	Үндсэн цалин	Хавсран %	Ур чадвар	Мэргэшсэн%	Нийт нэмэгдэл
1	Архив бичиг хэргийн эрхлэгч	Л.Оюун гэрэл	605,639	30	25	15	70
2	Техник, үйлчилгээний төвийн дарга	Г.Төмөр баатар	759,865	30	25	15	70

11.3. 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Албан тушаал дэвшүүлэх, төрийн албан хаагчийн цалингийн шатлал, ур чадварын нэмэгдлийг шинэчлэн батлах тухай” 24 дүгээр тушаал

Д/д	Албан тушаал	Овог нэр	Үндсэн цалин	Хавсран %	Удаан жил	Ур чадвар	Зэрэг %	Мэргэшсэн%	Нийт нэмэгдэл
1	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Л.Оюун гэрэл	526,642	30	0	25	0	15	70
2	Техник, үйлчилгээний төвийн дарга	Г.Төмөр баатар	660,752	30	0	25	0	15	70
3	Ерөнхий санхүүч	Б.Оюун	692,117	20	25	0	28	15	88

Дээрх албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2.2, мөн ЗГ-ын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 96 дугаар тогтоолын 3-т “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох бүх төрлийн нэмэгдлийн нийт хэмжээ нь: Төрийн захиргааны болон тусгай албан хаагчдын хувьд түүний албан тушаалын сарын цалин, бүх төрлийн нэмэгдлийн дүнгийн 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосугай” гэж заасныг зөрчсөн байна.

12. 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Шагнах тухай” 89 дүгээр тушаалаар Шатахууны импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд БНХАУ-ын “Чайна ойл” компанитай шатахуун нийлүүлэх гэрээг амжилттай байгуулж, зах зээлд нийлүүлэх ажлыг олон нийтэд сурталчилан зохион байгуулсан 2 албан хаагчийг 15 сая, **ГТБХХ-ийг 2 сая, АОХ-ийг 1 сая, ҮТТХ-ийг 1 сая төгрөгөөр**, нийт 19 сая төгрөгөөр шагнасан нь ЗГАЭЗБТХ-ийн 17.1.2 дахь заалтыг зөрчсөн байна.

13.1. 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” 219 дугаар тушаалаар ГТХайгуулын Чойр XXV, Ар Булаг XXIX талбайд захиалга ирүүлсэн компаниудын захиалга, холбогдох бичиг баримтыг судлан хянаж, үнэлгээ хийсэн Ажлын хэсэг болон Үнэлгээний хорооны 9 гишүүдэд өдрийн 200,000 төгрөг, нийт 10,600,000 төгрөгийн урамшуулал,

13.2. 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Урамшуулал тухай” 203 дугаар тушаалаар гэрээлэгч сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдэд нийт 4,500,000 төгрөгийн урамшуулал олгосон байна.

ҮХС-ын 2008 оны “БХГ-ний Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам батлах тухай” 33 дугаар тушаалын 7.6-д “Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар хавсралтад заагдсан талбай авах захиалгын захиргааны үйлчилгээний шимтгэлээс Гэрээлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг санхүүжүүлнэ. /Зарлан нийтлэх, шаардлагатай материал бэлтгэх, СШЗ, үнэлгээний хороо болон Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдон гарах томилолт, байр, замын зардал, урамшуулал зэрэг бусад зардал орно/” гэж заасан байна. Тус тушаалд хэдэн төгрөгөөр урамшуулах тухай нарийвчлан тусгаагүй байна. Иймд тус тушаалыг шинэчлэн боловсруулах саналтай байна.

14. 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “Сургалт зохион байгуулах тухай” 152 дугаар тушаалаар Байгууллагын ажилтнуудад зориулсан хувь хүнийг хөгжүүлэх сургалтыг 5,642,250 төгрөгөөр “River beach” амралтын газарт зохион байгуулсан байна.

ГТГ-ын даргын 2015.01.15-ны өдрийн 08 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 9.3-т “Ажил мэргэжлийн онцлогтой уялдуулан биеийн тамираар хичээллэх хөтөлбөрийг баталж, ажилтнуудыг чийрэгжүүлэх арга хэмжээ авна. Газрын биеийн тамирын хамтлаг байгуулж, ажилтнуудын дунд биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, тойрон аялал болон соёл, олон нийтийн өдөрлөг, уулзалт цэнгүүн зэргийг зохион байгуулж, тэдний биеийн тамир спортын ба олон нийтийн арга хэмжээнд жил бүр зохих хөрөнгө төлөвлөж зарцуулна” гэж заасан ба сургалт зохион байгуулах талаар тусгаагүй байна.

15. 2014 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн “Төрийн албанаас түр чөлөөлөх тухай” 110 дугаар тушаалаар нягтлан бодогч Д.Можулд 6 сарын цалинтай тэнцэх мөнгөн тусламж олгосон нь ЗГ-ын 2004 оны “Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам батлах тухай” 112 дугаар торгтоолын 2-т “Төрийн албаны тухай хуулийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байсан байгууллага нь олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

3. Боловсон хүчний чиглэлээр

Газрын тосны газар нь 8 хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байгаагаас Захиргаа удирдлагын хэлтэс батлагдсан орон тоо 21-20, Хайгуул, судалгааны хэлтэс 20-19, Ашиглалт, олборлолтын хэлтэс 16-15, Газрын тосны бүтээгдхүүний хангамжийн хэлтэс 12-11, Үйлдвэрлэл, техник технологийн хэлтэс 11-11, Гэрээлэлт, эрх зүйн хэлтэс 5-4, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс 10-9, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс 6-6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоол болон Уул уурхайн сайдын 2015 оны 18 дугаар тушаалаар Газрын тосны газарт 101 орон тоо батлагдсан.

Газрын тосны газарт 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар Төрийн жинхэнэ албан хаагч 63, хөдөлмөрийн гэрээгээр 28 /жолооч, үйлчлэгч/, ажил гүйцэтгэх гэрээгээр 8 албан хаагч ажиллаж байна. Үүнд :

Лхамсүрэнгийн Баярмандал Хайгуул судалгааны хэлтэст Геофизикийн судалгаа хариуцсан мэргэжилтнээр 2014 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 126 дугаар тушаалаар, Баттогтохын Билгүүн Ашиглалт, олборлолтын хэлтэст Тамсаг-21 талбайн газрын тосны олборлолт, хадгалалт, тээвэрлэлт хариуцсан мэргэжилтнээр 2015 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 41 дугаар тушаалаар, Оюунбилэгийн Баярмаа Гэрээлэлт эрх, зүйн тасагт

Газрын тосны бүтээгдэхүүний эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнээр 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 199 дүгээр тушаалаар, “Тамсаг” 21 дүгээр талбайн жолоочоор Баатарын Галсандорж болон “Тосон-Уул” 19 дүгээр талбайн жолоочоор Баатарын Хүдэрчулуун нар 2015 оны 3 дугаар 26-ны өдрийн 42 дугаар тушаалаар, Даваахүүгийн Хадбаатар Хайгуул судалгааны хэлтэст Геофизикийн судалгаа хариуцсан мэргэжилтнээр 2014 оны 8 дугаар 25-ны өдрийн 128 дугаар тушаалаар, Хөдөлмөрийн гэрээгээр Минжингийн Батбаяр Хайгуул судалгааны хэлтэст Мэдээллийн сан хариуцсан ажилтнаар 2014 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 126 дугаар тушаалаар түр томилогдон ажиллаж байна.

Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа 8 албан хаагчийн 4 нь урт хугацааны сургалтанд хамрагдсан төрийн албан хаагчийн орон тоон дээр ажиллаж байгаа ба нийт сул 10 орон тоог нөхөж, ТАЗ-өөр сонгон шалгаруулалт зарлуулаагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 17.1 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө”, 17.3 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хүсэлтэй, энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид “мэргэшлийн шалгалт” гэх/ авч онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ”, 17.5 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

4. Төсөв санхүүгийн чиглэлээр.

4.1 Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материалын тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах ажлын хүрээнд:

Тус газар нь 2013-2014 онд Төрийн сангийн 9000180002, Төрийн банкинд Сургалтын урамшууллын сангийн 2400256294, Үйлчилгээний орлогын 2400256283, Экспортын орлогын 2400256261, Төлөөлөгчийг дэмжих сангийн 2400269815 тоот, Хаан банкинд 5076209907 тоот данс /касс/-аар тус тус гүйлгээг хийж, санхүүгийн үйл ажиллагаанд 2013-2014 онд 1 дүгээр гарын үсгийг Г.Өлзийбүрэн, 2 дугаар гарын үсгийг Б.Оюун нар зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

4.1.1. Экспортын орлогын 2400256261 дансанд:

Тус дансны 2013 оны эхний үлдэгдэл 9,723,097.21 ам.доллар байсан ба 136,569,672.61 ам.долларын орлогын гүйлгээ хийгдэж, 145,872,769.82 ам.долларын зарлагын гүйлгээ гарч, оны эцэст 420,000.0 ам.доллар /696,922.8 мянган төгрөг/-ийн үлдэгдэлтэй болсон байна.


МУ-ын 2013 оны Төсвийн тодотголоор Газрын тосны экспортын орлогоос улсын төсөвт 161,7 тэрбум төгрөг, талбайн дэнчин болон бусад орлогоос 2,7 тэрбум төгрөг тус

тус төвлөрүүлэхээс тосны экспортын орлогоос 187,7 тэрбум төгрөг /145.684.5 мянган ам.доллар/, бусад орлогоос 3,5 тэрбум төгрөг /2,336.3 мянган ам.доллар/, нийт 191,2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 16,3 хувь буюу 26,8 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлжээ.

2014 онд газрын тосны борлуулалтын орлогоор улсын төсөвт 218,2 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 285,5 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 30,9 хувь буюу 67,3 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

/сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2013 он		Биелэлт		2014 он		Биелэлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Газрын тосны экспортын орлого /МУ-ын ЗГ-т ногдох/	161,721.3	187,666.4	25,945.1	116,0	218,198.1	285,552.5	67,354.4	130,9
2	Бусад орлого	2,700.0	3,493.2	793.2	129,4	2,970.0	2,979.7	9.7	100,3
	Дүн	164,421.3	191,159.6	26,738.3	116,3	221,168.1	288,532.2	67,364.1	130,5



2013 онд “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-аас өмнөх оны экспортын орлогын авлага 7,453.4 сая төгрөг, тухайн оны экспортын орлого 147,467.8 сая төгрөг, нийт 154,921.2 сая төгрөгийг бүрдүүлж, 12 сард ачуулсан газрын тосны орлого 21,044.3 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

“Доншен газрын тос” ХХК-аас өмнөх оны экспортын орлогын авлага 3,345.4 сая төгрөг, тухайн оны экспортын орлого 20,155.8 сая төгрөг, нийт 23,501.2 сая төгрөгийг бүрдүүлж, 12 сард ачуулсан газрын тосны орлого 4,314.2 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Харилцахын хүүгийн орлогын 284,256.8 мянган төгрөг /188,3 мянган ам.доллар/-ийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Сангийн яамны 2013 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 10-1/339 тоот “Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэр, Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу тус яамны зүгээс гадаад зээлийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлж, авлага барагдуулах үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын шугамаар Япон Улсын МОН-С1 дугаартай барааны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс танай байгууллагад олгосон **2,109,050.78 ам.доллар /2,937,232.8 мянган төгрөг/-ийн** авлага Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд бүртгэлтэй байна. Иймд дээрх төлбөрийг Сангийн яамны Монгол банкн дахь 3332403 ам.долларын дансанд төвлөрүүлнэ үү.” гэсэн албан бичгийн дагуу дээрх төлбөрийг шилжүүлсэн байна.

Бусад орлогод Төрийн банкны Төлөөлөгчийг дэмжих сан, Сургалтын урамшууллын сан, үйлчилгээний орлогын дансанд төвлөрсөн орлогыг тусгажээ.

Төлөөлөгчийг дэмжих сан, Сургалтын урамшууллын сан, үйлчилгээний орлого /захиргааны үйлчилгээний шимтгэл, газрын түрээс, ашиглалт олборлолтонд шилжсэний төлбөр, гарын үсгийн урамшуулал/-ыг төлөвлөхдөө БХГ-г үндэслэн хийж байна.

4.1.2 Үйлчилгээний орлогын дансанд:

2013 оны эхний үлдэгдэл 239,5 мянган ам.долларын үлдэгдэлтэй байсан ба 10,9 мянган ам.долларын хүүгийн орлого, гарын үсгийн урамшуулал 200,0 мянган ам.доллар /Вульфпетролиум ХХК/, ашиглалт /Петрочайна Дачин Тамсаг Монгол ХХК/, олборлолт /Доншен Газрын тос Монгол ХХК/-д шилжсэний 150,0 мянган ам.доллар, гэрээний сунгалтын /Шейман ХХК/ төлбөр 25,0 мянган ам.доллар, геологийн судалгааны багц материалын үнэнд 50,0 мянган ам.доллар, захиргаа, үйлчилгээний шимтгэлд 50,0 мянган ам.доллар, талбайн дэнчингийн төлбөр 1,328.3 мянган ам.доллар төлөгдөхөөс 1,095.0 мянган ам.доллар, Капкорп ХХК-аас сургалтын урамшууллын төлбөр 14,7 мянган ам.доллар, буцсан гүйлгээ 334,48 ам.доллар, буцаан тушаасан 1.140 ам.доллар, нийт 1,597.1 мянган ам.долларын орлого орж, 1,836.6 мянган ам.долларын зарлагын гүйлгээ хийгдэж, оны эцэст үлдэгдэлгүй болсон байна.

		Тусгай зөвшөөрөл /талбайн дэнчин/-ийн төлбөр				/ам.доллар/			
№	Компанийн нэр	Эхний үлдэгдэл	2013 он		Үлдэгдэл	2014 он		Эцсийн үлдэгдэл	Нийт зөрүү
			Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь		Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь		
1	Петро Матад ХХК	-	103,432	103,432	-	103,432	-	-103,432	-103,432
2	Петро Чайна Дачин Тамсаг ХХК	-	314,576	314,576	-	209,108	209,108	-	-
3	Доншен газрын тос ХХК	-	62,790	41,506	-21,284	62,790	62,790	-	-21,284
4	Голдэн Сий петролиум ХХК	31,197	62,394	31,197	-62,394	62,394	31,193	-31,201	-93,595
5	Шейман ХХК	-	36,960	-	-36,960	36,956	-	-36,956	-73,916
6	DWM Petroleum ХХК /Гоби Энержи Партнерс/	-	34,912	12,072	-22,840	12,043	22,840	-12,043	-12,043
7	Зон Хэн Юу Тиан	-	39,077	39,077	-	39,077	39,077	-	-
8	Сентрал Азиан Петролеум корпорейшн лимитед ХХК /Капкорп ХХК/	-	200,593	-	-200,593	200,593	-	-200,593	-401,186

9	Эн Пи Ай ХХК	39,444	39,444	39,444	-39,444	21,104	21,104	-	-39,444
10	Импайр газ ХХК /М Си Эс ХХК/	-	125,720	125,720	-	125,720	125,720	-	-
11	Сансрын геологи хайгуул ХХК	181,641.2	132,981	265,454	-49,168	113,815	-	-113,815	-162,983
12	Шунхлай энерги ХХК	-	54,300	-	-54,300	54,300	108,600	-	-
13	Алекспро инвестмент ХХК	-	34,360	34,360	-	68,720	68,720	-	-
14	Магнайтрейд ХХК	14,049	46,995	15,665	-31,330	31,330	31,254	-75	-45,454
15	МАК ХХК	-	49,412	49,412	-	49,412	-	-	-49,412
16	Вульф петролиум	-	23,048	23,048	-	46,095	46,095	-	-
	Нийт дүн	266,331.2 \$	1,360,994 \$	1,094,963 \$	518,313 \$	1,236,889 \$	766,501 \$	498,115 \$	-1,002,749 \$

Үйлчилгээний орлогын данснаас улсын төсөвт 2,321,375.4 мянган төгрөг /1,548.5 мянган ам.доллар/-ыг төвлөрүүлж, харилцахын хүүгийн орлогын 10,9 мянган ам.долларыг Төлөөлөгчийг дэмжих сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалаар батлагдсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээний Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг зөрчиж, Үндэсний Аудитын газрын 2013 онд “Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн шалгалтаар тогтоосон 2013.10.10-ны өдрийн 01/79 тоот “Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлгүй, Хан-Уул дүүргийн Өвөр зайсан дахь Бугат ажиллагсдын зуслан барихад зарцуулсан” актын төлбөр 207,669.5 мянган төгрөг /128,191.08 ам.доллар/, 2013.10.10-ны өдрийн 01/75 “Тайлан балансад тусгалгүйгээр Хаан банкны дансуудад орлогыг нуун дарагдуулж тайлагнаагүй зөрчил”-д тогтоосон актын төлбөрт 142,135.9 мянган төгрөг /76,627.09 ам.доллар/, нийт 349,805.4 мянган төгрөг /204,818.17 ам.доллар/-ийг шилжүүлж, зориулалт бусаар зарцуулсан байна.

Бусад зарлагыг Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалаар батлагдсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээний Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу гэрээлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

4.1.3. Төрийн сангийн дансны гүйлгээний талаар:

4.1.3.1 2013 оны батлагдсан төсөвт зардал, түүний гүйцэтгэлийн талаар:

Газрын тосны газрын 2013 оны төсөвт зардалд 3,528.2 сая төгрөг батлагдсанаас 3,509.4 сая төгрөгийг зарцуулж, төсөв 18,8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Батлагдсан нийт төсвийг зардлын зүйл бүрээр авч үзэхэд 231,9 сая төгрөгөөр хэмнэгдэж, 213,1 сая төгрөгөөр хэтэрсэн нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнийг харуулж байна.

2013 он /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3 528 203 900	3 509 378 783	-18 825 117
2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3 528 203 900	3 509 378 783	-18 825 117
3	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1 247 742 700	1 247 741 852	-848
4	Үндсэн цалин	1 009 064 000	1 022 282 917	13 218 917
5	Нэмэгдэл цалин	104 122 800	111 053 238	6 930 438
6	Унаа, хоолны нэмэгдэл	70 000 000	63 407 921	-6 592 079
7	Гэрээт цалин	64 555 900	50 997 775	-13 558 125
8	АО-оос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132 251 700	132 251 129	-571

9	Тэтгэврийн даатгал	82 342 000	128 889 381	46 547 381
10	Тэтгэмжийн даатгал	9 981 900	420 219	-9 561 682
11	ҮОМШ өвчний даатгал	12 477 400	840 437	-11 636 963
12	Ажилгүйдлийн даатгал	2 495 500	420 219	-2 075 282
13	Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	24 954 900	1 680 874	-23 274 026
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162 067 800	143 504 741	-18 563 059
15	Гэрэл цахилгааны зардал	40 100 000	15 790 393	-24 309 607
16	Түлш, халаалтын зардал	76 000 000	84 925 996	8 925 996
17	Цэвэр, бохир усны зардал	25 000 000	8 815 651	-16 184 349
18	Байрны түрээсийн зардал	20 967 800	33 972 701	13 004 901
19	Хангамж, бараа материалын зардал	107 548 700	107 544 154	-4 546
20	Бичиг хэргийн материал	7 857 200	11 681 345	3 824 145
21	Тээвэр, шатахууны зардал	92 588 600	78 428 950	-14 159 650
22	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	7 102 900	17 433 859	10 330 959
23	Нормативт зардал	5 000 000	5 000 000	0
24	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5 000 000	5 000 000	0
25	Эд хогшил, урсгал засварын зардал	3 500 000	3 199 500	-300 500
26	Жижиг эд хогшил худалдан авах	3 500 000	3 199 500	-300 500
27	Томилолт, зочны зардал	253 929 000	253 920 634	-8 366
28	Гадаад албан томилолтын зардал	38 119 000	128 170 925	90 051 925
29	Дотоод албан томилолтын зардал	154 590 000	81 703 978	-72 886 022
30	Зочин төлөөлөгч хүлээн авах	24 800 000	19 830 850	-4 969 150
31	Сургалт, семинар зохион байгуулах	10 620 000	7 179 300	-3 440 700
32	Гадаад сургалт, семинар зохион байгуулах	25 800 000	17 035 581	-8 764 419
33	Бусад бараа ажил, үйлчилгээний зардал	213 330 000	198 392 790	-14 937 210
34	Урсгал засварын зардал	49 921 300	48 244 962	-1 676 338
35	Аудитын баталгаажуулалт, зэрэглэл	83 200 000	80 751 844	-2 448 156
36	Даатгал-Тээврийн хэрэгслийн Улс орноо гадаадад	6 020 000	3 500 950	-2 519 050
37	сурталчлах	5 400 000	1 667 700	-3 732 300
38	Газрын төлбөр	6 500 000	10 481 512	3 981 512
39	Төр. өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлч. төлбөр	14 800 000	14 794 222	-5 778
40	Харуул, хамгаалалтын зардал	42 724 000	38 451 600	-4 272 400
41	Гэнэтийн ослын даатгал	4 424 700	0	-4 424 700
42	Шагнал урамшуулал	340 000	500 000	160 000
43	Бараа үйлчилгээний бусад зардал	4 544 500	14 676 780	10 132 280
44	Төлбөр, хураамж, жижиг татварууд	4 544 500	14 676 780	10 132 280

45	Бусад урсгал шилжүүлэг	1 398 289 500	1 403 147 203	4 857 703
46	Сургалтын буцалтгүй тусламж	1 365 000 000	1 363 870 465	-1 129 535
47	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33 289 500	39 276 738	5 987 238
48	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3 528 203 900	3 509 378 783	-18 825 117
49	Улсын төсвөөс санхүүжих	3 528 203 900	3 509 378 783	-18 825 117
50	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		15 362 572 550	
51	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1 199 592 548	
52	Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		14 181 805 120	
53	Нийт хэтрэлт			-213 095 692
54	Нийт хэмнэлт			231 920 809

Хэтэрсэн зардлын талаар:

- ✓ Газрын тосны газрын лабораторийн 7 аймгийн төлөөлөгчийн албадуудын байрны түрээс нэмэгдсэнээр байрны түрээсийн зардал хэтэрсэн.
- ✓ Шуудан холбоо, интернетийн төлбөрт интернетийн төлбөр 7,070.8 мянган төгрөг, иридиум утасны төлбөрт 531,4 мянган төгрөг, 99112526 гар утасны төлбөр 1,366.8 мянган төгрөг зэрэг зардлуудыг тусгажээ.
- ✓ 2013 онд лабораторийн барилга ашиглалтанд орж ус, дулааны зардал нэмэгдсэнээр түлш халаалтын зардал хэтэрсэн байна.
- ✓ Хөдөө орон нутгийн 7 газрын төлөөлөгчийн байрны түрээс нэмэгдсэнээр байрны түрээсийн зардал хэтэржээ.
- ✓ Төлбөр хураамж, жижиг татварын зардалд УУ-н дэд сайдын ярилцлаганы төлбөр 1,320.0 төгрөг, машины гражийн түрээст 1,155.0 мянган төгрөг, шалавч, хальсны үнэнд 731.0 мянган төгрөг, барааны үнэнд 1,372.3 мянган төгрөг, Содонвишн ХХК-луу вэбсайтын урьдчилгаа 2,475.0 төгрөг, хэвлэл захиалгын үнэнд 1,828.5 төгрөг шилжүүлсэн зэрэг зардлуудыг тусгажээ.
- ✓ Гадаад томилолтын зардлын төсвийг үндэслэлгүйгээр бага баталж өгсөн ба газрын тосны бүтээгдэхүүн хангамжийг хэвийн байлгах шаардлагын үүднээс ОХУ, БНХАУ-д айлчлах айлчлалын хэмжээ нэмэгдсэнээс гадаад томилолтын зардал 90,1 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

4.1.3.2 2014 оны батлагдсан төсөвт зардал, түүний гүйцэтгэлийн талаар:

Газрын тосны газрын 2014 оны төсөвт зардалд 4,547.6 сая төгрөг батлагдсанаас 4,536.3 сая төгрөгийг зарцуулжээ. Төсвийг зардлын зүйл тус бүрээр авч үзэхэд 19 төрлийн зардал 166,5 сая төгрөгөөр хэмнэгдэж, 4 төрлийн зардал 74,9 сая төгрөгөөр хэтэрч төсвийн хэмнэлтээс 82,4 сая төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

2014 он /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,547,632,600.0	4,536,278,156.0	11,354,443.9
2	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,365,621,900.0	1,365,572,452.3	49,447.7
3	Үндсэн цалин	1,111,772,200.0	1,111,727,531.1	44,668.9
4	Гэрээт болон Нэмэгдэл цалин	183,849,000.0	183,845,781.9	3,218.1
5	Унаа,хоолны нэмэгдэл	70,000,700.0	69,999,139.3	1,560.7

6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд	150,218,400.0	150,170,951.5	47,448.5
8	Ашиглалтын тогтмол зардал	164,221,000.0	114,945,963.7	49,275,036.3
9	Гэрэл цахилгааны зардал	44,200,000.0	16,956,590.1	27,243,409.9
10	Түлш, халаалтын зардал	71,400,000.0	65,402,675.5	5,997,324.5
11	Цэвэр, бохир усны зардал	29,750,000.0	8,791,406.0	20,958,593.9
12	Байрны түрээсийн зардал	18,871,000.0	23,795,292.0	-4,924,292.0
13	Хангамж, бараа материалын зардал	106,171,200.0	89,304,034.1	16,867,165.9
14	Бичиг хэргийн материал	8,745,000.0	3,989,685.0	4,755,315.0
15	Тээвэр, шатахууны зардал	90,097,500.0	72,211,120.0	17,886,380.0
16	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	7,328,700.0	13,103,229.1	-5,774,529.1
17	Нормативт зардал	4,250,000.0	4,250,000.0	0.0
18	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,250,000.0	4,250,000.0	0.0
19	Эд хогшил, урсгал засварын зардал	56,733,100.0	56,723,497.9	9,602.0
20	Багаж техник хэрэгсэл	2,400,000.0	4,624,460.0	-2,224,460.0
21	Урсгал засварын зардал	54,333,100.0	52,099,037.9	2,234,062.0
22	Томилолт, зочны зардал	183,503,800.0	179,356,447.0	4,147,353.0
23	Гадаад албан томилолтын зардал	36,872,500.0	98,886,356.0	-62,013,856.0
24	Дотоод албан томилолтын зардал	118,261,300.0	78,875,891.0	39,385,409.0
25	Зочин төлөөлөгч хүлээн авах	28,370,000.0	1,594,200.0	26,775,800.0
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	145,784,300.0	143,136,665.3	2,647,634.7
27	Аудитын баталгаажуулалт, зэрэглэл	50,000,000.0	49,999,916.0	84.0
28	Даатгал-Тээврийн хэрэгслийн	8,720,000.0	8,700,000.0	20,000.0
29	Мэдээлэл сурталчилгаа	5,440,000.0	4,991,150.0	448,850.0
30	Газрын төлбөр	15,000,000.0	12,823,912.0	2,176,088.0
31	Төр. өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлч. төлбөр	15,355,300.0	15,353,557.3	1,742.7
32	Харуул, хамгаалалтын зардал	51,269,000.0	51,268,130.0	870.0
33	Бараа үйлчилгээний бусад зардал	24,000,000.0	22,939,401.0	1,060,599.0
34	Төлбөр, хураамж, жижиг татварууд	24,000,000.0	22,939,401.0	1,060,599.0
35	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,347,128,900.0	2,409,878,743.2	-62,749,843.2
37	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	82,397,556.4	-82,397,556.4
39	Сургалтын буцалтгүй тусламж	2,246,980,000.0	2,231,030,820.8	15,949,179.2
40	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	32,939,100.0	30,166,929.0	2,772,171.0
41	Урамшуулал, нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,209,800.0	66,283,437.0	926,363.0
42	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,516,097,450.0	4,536,278,156.0	-20,180,706.0
43	Улсын төсвөөс санхүүжих	4,516,097,450.0	4,516,097,450.0	0.0
44	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	20,180,706.0	-20,180,706.0
45	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		1,197,097,794.6	
46	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		781,215,582.3	
47	Төсвийн нийт хэмнэлт		166,513,049.5	
48	Төсвийн нийт хэтрэлт		-74,937,137.1	

Тус байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,199,592.5 мянган төгрөгөөр баталгаажсан байсан боловч Сангийн яамнаас өгсөн

чиглэлээр валютын дансны үлдэгдлийг 12 дугаар сарын 30-ны өдрийн ханшаар тооцож хөрвүүлсэн, Хөрөнгө оруулалтын үндэсний банкин дахь дансны үлдэгдлийг тайланд нэмж тусгуулснаас 2014 оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,197,097.8 мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Тус байгууллага 2014 оны эхэнд 1,197.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 781,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Төсвийн хэмнэлтийн талаар:

✓ Төсвийн нийт хэмнэлтийн 60 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлуудын хэмнэлт эзэлж байгаа нь 2014 оны 2 дугаар сард өргөтгөлийн байр бүрэн ашиглалтад ороогүй зэргээс шалтгаалсан байна.

✓ Тээвэр шатахуун, бичиг хэрэг, дотоод томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлуудын хэмнэлт нь төсвийн төлөвлөлтийг өндөр дүнгээр батлуулснаас буюу төлөвлөлтийн алдаанаас шалтгаалсан байна.

Төсвийн хэтрэлтийн талаар:

Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийг хэвийн байлгах шаардлагын үүднээс ОХУ, БНХАУ-д айлчлах айлчлалын хэмжээ нэмэгдсэнээс Гадаад томилолтын зардал 62,0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Шуудан холбооны зардал хэтэрсэн гол шалтгаан нь сансарын холбооны Иридиум утасны төлбөрт 5,092.6 мянган төгрөг төлсөн буюу хэрэглээ хэт өндөр гарснаас, мөн өмнөх оны интернэтийн төлбөрт 1,592.2 мянган төгрөг төлсөн зэргээс шалтгаалсан.

Байрны түрээсийн зардлын хэтрэлт нь байгууллагын гражийг ашиглалгүй хувь хүмүүстэй гэрээ хийж 09-77 УНЭ автомашины гаражийн төлбөрт 1,111.5 мянган төгрөг, 05-67 УБҮ автомашины гаражийн төлбөрт 1,620.0 мянган төгрөг төлж үр ашиггүй зардал гаргасан, Төлөөлөгчийн байрнуудын түрээс нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

4.1.3.3 Үндсэн хөрөнгийн талаар:

№	Үндсэн хөрөнгө	Эхний үлдэгдэл	2013 он		Эцсийн үлдэгдэл	2014 он		Эцсийн үлдэгдэл
			Нэмэгдсэн	Хасагдсан		Нэмэгдсэн	Хасагдсан	
1	Барилга байгууламж	2,210,416.8	1,110,122.4		3,320,539.2	-	-	3,320,539.2
2	Тавилга эд хогшил	318,998.9	46,712.4	4,574.4	361,137.1	1,812,069.4	4,259.0	5,128,349.6
3	Тоног төхөөрөмж	553,415.0	151,861.7 4,574.4	-	709,851.0	162,106.9	36,042.6	487,201.4
4	Тээврийн хэрэгсэл	1,561,459.9	682,620.2	249,929.5	1,994,150.6	667,436.6	193,950.9	1,183,336.7
5	Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж	566,311.8	-	-	566,311.8	725,010.5	533,078.3	2,186,082.8
6	Бусад хөрөнгө	104,100.2	-	-	104,100.2	0	0	566,311.8
	Нийт дүн	5,314,702.6	1,991,316.6	254,503.9	7,056,089.9	9,900.0	0	114,000.2

2013 онд 715,380.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн ба 1,275,936.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг БХГэрээний дагуу төвлөрүүлсэн хөрөнгөнөөс худалдан авч, 249,929.5 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балсансад шилжүүлжээ.

Барилга байгууламж данс: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 695,319.8 мянган төгрөгийн ГТГ-ын Лабораторийн барилга, БХГэрээний дагуух Төлөөлөгчийг дэмжих

сангийн хөрөнгөөр 414,802.6 мянган төгрөгийн контейнер 7 ширхэг, нийт 1,110,122.4 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Тавилга эд хогшил данс: Төсвийн хөрөнгөөр 2,525.0 мянган төгрөг, БХГэрээний дагуух Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 44,187.4 мянган төгрөг, нийт 46,712.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна.

Тээврийн хэрэгсэл данс: Тус дансанд ТӨХ-ны 2013 оны 07 дугаар сарын 05-ны 421 дүгээр тогтоолоор 560,0 сая төгрөгт багтаан 6 ширхэг автомашиныг худалдан авахыг зөвшөөрсний дагуу ТДС-ийн хөрөнгөөр 563,835.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдаж авсан, төсвийн хөрөнгөөр 17,205.7 мянган төгрөг, ТДС-ийн хөрөнгөөр 33,369.4 мянган төгрөг, нийт 50,575.2 мянган төгрөгөөр сэлбэг хэрэгсэл худалдан авсныг капиталжуулжсанаар нэмэгджээ.

Мөн “Эм Эм И” ХХК-ны Газрын тосны газартай байгуулсан Газрын тосны судалгааны гэрээний 3.4.9-д “Компани энэхүү гэрээний 3.1.3-т заасан ГТГ-аас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашиныг худалдан авч ГТГ-т буцалтгүйгээр өгнө.” гэж заасны дагуу Тоёото Лэнд круйзер-78 /96-87 УБҮ/ маркийн 68,209.4 мянган төгрөгийн үнэтэй автомашиныг худалдан авч Газрын Тосны газарт хүлээлгэн өгсөнөөр нийт 632,045.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнд:

1. Ландкруйзер-76 /87-39 УНВ/- 87,355.3 мянган төгрөгөөр Таван богд ХХК-иас,
2. Ландкруйзер-76 /71-56 УНВ/- 87,355.3 мянган төгрөгөөр Таван богд ХХК-иас,
3. Венер газ 330811 /84-36 УНВ/- 82,000.0 мянган төгрөгөөр Цахир хад-Улаан нүүр ХХК-иас,
4. Ландкруйзер-200 /96-16 УНА/- 134,000.0 мянган төгрөгөөр Таван богд ХХК-иас,
5. Соната-7 /73-62 УНВ/- 47,200.0 мянган төгрөгөөр Монгол хьюндай автомотив ХХК-иас,
6. Форд экспедишн /09-77 УНЕ/- 125,925.0 мянган төгрөгөөр Вагнер Ази Автомотив ХХК-иас, нийт 563,835.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Дээрх тогтоолын дагуу 249,929.5 мянган төгрөгийн 6 ширхэг автомашиныг балансаас балансад шилжүүлжсэнээр хасагдсан байна. Үүнд:

1. Лонг TLC76 /УНБ 47-71/ 72,136.0 мянган төгрөгийн балансын үнэтэй /25,047.2 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ автомашин 2009 оны 12 сард ашиглалтанд орсон
2. Тоёото TLC70L WB /22-69 УБВ/ 48,978.5 мянган төгрөгийн балансын үнэтэй /4,000.0 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ 2007 оны 12 сард ашиглалтанд орсон, нийт 121,114.5 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 2 автомашиныг дуудлага худалдаагаар борлуулжээ.
3. Соната-6 /58-79 УНБ/ 29,083.0 мянган төгрөгийн балансын үнэтэй /12,530.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ 2009 оны 12 сард ашиглалтанд орсон,
4. Ниссан пикап /37-46 УНБ/ 34,866.0 мянган төгрөгийн балансын үнэтэй /12,590.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ 2008 оны 12 сард ашиглалтанд орсон,
5. Ниссан пикап /37-43 УНБ/ 34,866.0 мянган төгрөгийн балансын үнэтэй /12,106.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ 2008 оны 12 сард ашиглалтанд орсон,
6. Hyundai Truck, ачааны /87-65 УНЭ/ 30,000.0 мянган төгрөгийн балансын үнэтэй /24,583.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй/ 2012 оны 06 сард ашиглалтанд орсон, нийт 128,815.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг балансаас балансад шилжүүлсэн байна.

Тоног төхөөрөмж данс: Төсвийн хөрөнгөөр 330,0 мянган төгрөг, ТДС-ийн хөрөнгөөр 151,531.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 151,861.7 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан байна.

Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж данс: Лабораторийн зориулалттай хөрөнгийг энэ дансанд бүртгэжээ.

Бусад хөрөнгө данс: Газрын тосны газрын Улаанбаатар хот дах лаборатори, хилийн боомт болон бүс нутгийн төвүүд дэх газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лаборатори, төлөөлөгчийн газрын нийт 10 иж бүрэн барилгын зургыг МУ-ыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуульд “Шинээр баригдах барилга байгууламж, төсөл арга хэмжээний зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах” ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний тендерийг зарлан зохион байгуулж, барилгын зураг төслийн “Очиртааб” ХХК-тай 178 тоот гэрээ байгуулан ажилласан байна. Гэрээнд заагдсаны дагуу “Очиртааб” ХХК Улаанбаатар хот Дархан-Уул, Сэлэнгэ, Увс, Завхан, Дорнод, Говь-сүмбэр аймгууд болон Ховд аймгийн Ярант, Говь-Алтай аймгийн Бургастайн хилийн боомтуудад баригдах төлөөлөгчийн газар, лабораторийн барилгын зураг, төслийг боловсруулах ажлыг нийт 90.166,7 мянган төгрөгөөр гүйцэтгэсэнийг энэ дансанд бүртгэсэн байна.

Биет бус хөрөнгө 13,933.5 мянган төгрөгийг бүртгэсэн байна.

2014 онд 1,558,535.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн ба 415,900.1 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад, 1,168,335.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг БХГэрээний дагуу төвлөрүүлсэн хөрөнгөнөөс авч Конторын барилгын болон Дарханы төлөөлөгчийн байрны их засварт

Үүнээс Улсын төсвийн хөрөнгөөр 1,540,000.0 мянган төгрөгийн ГТГ-ын конторын өргөтгөлд, 18,535.0 мянган төгрөгийн сэлбэг, тавилга, тоног төхөөрөмж, БХГэрээний дагуух хөрөнгөөр 6 ширхэг 710,524.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, 53,536.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 126,064.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч 233,752.4 мянган төгрөгийн дотоод гүйлгээ /хөдөлгөөн/ хийгдсэн байна. 533,078.3 мянган төгрөгийн автомашиныг ТӨХ-ны 2014 оны 05 дугаар сарын 08 ны 246 дугаар тогтоолын дагуу балансаас балансад шилжүүлсэн байна.

Барилга байгууламж данс: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,595,000.0 мянган төгрөгийн ГТГ-ын конторын өргөтгөлийн барилга, БХГэрээний дагуух Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 950,0 мянган төгрөгийн үнэтэй 4 ханатай гэр, 2,808.9 мянган төгрөгийн үнэтэй 5 ханатай гэр худалдан авч, Конторын барилгын их засварт 176,525.4 мянган төгрөг, хашаанд 3,800.0 мянган төгрөг, Дарханы төлөөлөгчийн газрын их засварт 32,485.0 мянган төгрөг зарцуулж, нийт 1,811,569.3 мянган төгрөгөөр нэмэгджээ. 4,259.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 гэрийг балансаас хассан байна.

Тоног төхөөрөмж данс: 2014 онд 162,106.9 мянган төгрөгийн тавилга эд хогшлийг төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 4 компаниас харьцуулалтын аргаар худалдан авалт хийж, 36,042.6 мянган төгрөгийн эд хогшлийг балансаас хассан байна.

Тавилга эд хогшил данс: 2014 онд 667,436.6 мянган төгрөгийн тоног төхөөрмжийг /Компьютер, принтер, телевизор, хөргөгч, богино долгионы станц, зөөврийн лаборатори, интерактив 80 инч самбар/ төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 7 компаниас харьцуулалтын аргаар худалдан авалт хийж, 193,950.9 мянган төгрөгийн эд хогшлийг балансаас хассан байна.

Тээврийн хэрэгсэл данс: Тус дансанд Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөс 508,500.0 мянган төгрөгөөр, сургалтын сангийн хөрөнгөөс 200,000.0 мянган төгрөгийн

тээврийн хэрэгсэл худалдаж авсныг харуулбал: Төрийн өмчийн хорооны 2014 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 246 дугаар тогтоолын дагуу тусгай зориулалтын 45 хүний суудалтай Huidai County маркийн 1 ширхэг автобусыг Хьондай моторс ХХК-аас 158,500.0 мянган төгрөгөөр, Хөдөө ажлын Cheverolet ТАНОЕ маркийн 3 ширхэг автомашиныг Номин моторс ХХК-аас 390,000.0 мянган төгрөгөөр, мөн хөдөө ажлын Land Cruizer-70 маркийн 3 ширхэг автомашиныг 160,000.0 мянган төгрөгөөр нийт 708,500.0 мянган төгрөгөөр тээврийн хэрэгсэл худалдан авсан байна.

Мөн Lexus-570 маркийн 05-67 УБҮ улсын дугаартай автомашинд 4,989.5 мянган төгрөгийн, Land Cruizer-78 маркийн 96-87 УБҮ улсын дугаартай автомашинд 3,311.0 мянган төгрөгийн, Chairman маркийн 88-94 УБҮ улсын дугаартай автомашинд 8,210.0 мянган төгрөгийн сэлбэг худалдан авч нийт 16,510.5 мянган төгрөгөөр капиталжуулалт хийснээр тээврийн хэрэгсэл данс 725,010.5 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Төрийн өмчийн хорооны 2014 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 246 дугаар тогтоолын дагуу 533,078.3 мянган төгрөгийн балансын үнэтэй 7 ширхэг автомашиныг балансаас балансад шилжүүлжсэнийг харуулбал: Ашигт малтмалын газарт Land Cruizer-200 маркийн 32-43 УБЧ улсын дугаартай 165,176.0 мянган төгрөгийн балансын үнэтэй автомашиныг, Хилийн 0198 дугаар ангид Land Cruizer-200 маркийн 00-94 УНБ улсын дугаартай 95,878.4 мянган төгрөгийн балансын үнэтэй, Land Cruizer-200 маркийн 00-94 УНД улсын дугаартай 117,793.1 мянган төгрөгийн балансын үнэтэй 2 ширхэг автомашиныг, Тахарын ерөнхий газарт Ниссан пикап маркийн 37-42 УНБ улсын дугаартай 34,866.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, Ниссан пикап маркийн 37-41 УНБ улсын дугаартай 34,866.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, Ниссан пикап маркийн 37-40 УНБ улсын дугаартай 34,866.0 мянган төгрөгийн балансын үнэтэй 3 ширхэг автомашиныг, Үндэсний аялал жуулчлалын төвд Huidai маркийн 25 хүний суудалтай 37-50 УНБ улсын дугаартай 49,632.7 мянган төгрөгийн балансын үнэтэй автобусыг тус тус шилжүүлсэн байна.

Бусад хөрөнгө:

2014 онд 9,900.0 мянган төгрөгөөр “Ординат” ХХК-аас сургалтын сангийн хөрөнгөөр санхүүгийн программ худалдан авч бусад хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн. Хасагдсан хөрөнгө байхгүй.

4.1.3.4 Байгууллага, хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажилт, бүртгэл тайлан тэнцэлд тусгасан байдал:

1. Авлага		/ Мянган төгрөг /			
№	Авлагын ангилал	2013 он		2014 он	
		Эхэнд	Эцэст	Эхэнд	Эцэст
1	Бусад авлага	12,706,643.8	28,487,654.8	28,487,654.8	6,361,972.5
2	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,900,059.2	1,908,610.1	1,908,610.1	1,948,377.1
	Нийт дүн	14,606,703.0	30,396,264.9	30,396,264.9	8,310,349.7

Бусад авлага: 2013 оны авлагын эхний үлдэгдэлд 2012 оны газрын тосны авлага “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 7,819.0 сая төгрөг, “Доншен Монгол” ХХК-ийн 3,345.4 сая төгрөг, “Шунхлай” ХХК-ийн 208.8 сая төгрөг, “Петроматад” ХХК-ийн 55,7 сая төгрөг, “Капкорп” ХХК-ийн 55,7 сая төгрөг, “Голден сий” ХХК-ийн 154,8 сая төгрөг, “Эн Пи Ай” ХХК-ийн 74,5 сая төгрөг, “Сансарын геологи хайгуул” ХХК-ийн 628,7 сая төгрөг, “Гоби энерги” ХХК-ийн 139,2 сая төгрөг, “МАК” ХХК-ийн 222,7 сая төгрөг, нийт 12,706.6 сая төгрөгийн авлага тусгагдсан байна. 2013 оны авлагын эхний үлдэгдэлд дараах тайлбарыг өгсөн.

№	Компани	2012 оны үлдэгдэл /₮/	МБ-ны 2012.12.31- ний ханш	2012 оны үлдэгдэл /\$/	Тайлбар
1	Дачин	7,818,987,160.6	1,392.10	5,616,684.98	Түүхий тосны орлого
2	Доншен	3,345,379,941.0	1,392.10	2,403,117.55	Түүхий тосны орлого
3	Шунхлай	208,815,000.0	1,392.10	150,000.00	Сургалтын урамшуулал 95,000\$, төлөөлөгчийн газрыг дэмжих 55,000\$-ын үлдэгдэлтэй байсан. Гэвч УУЯ-ны 2014.11.14-ний өдрийн 6-1/118 тоот албан бичигт тус компаний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь 2010.10.07-ны өдрийн УУС-ын тушаалаар гарсан тул 2009 онд БХГ байгуулсан хугацааг тусгай зөвшөөрөл гарсан өдрөөр тооцох талаар чиглэл өгсөн. Тиймээс өглөггүй болж залруулагдсан болно.
4	Капкорп	111,368,000.0	1,392.10	80,000.00	Энэ нь Доншен ХХК-ний 2012 онд төлсөн төлөөлөгчийг дэмжих сангийн 30,000\$, олборлолтод шилжсэний урамшуулал 50,000\$ байсныг авлагат Капкорп компаний нэрээр буруу бүртгэсэн байна. Уг төлбөр нь 2012.12.24-нд шилжиж ирсэн тул төлбөрийн үлдэгдлийг санхүүд гаргаж өгсний дараа шилжин орж ирсэн байна.
5	Голден сий	154,797,232.3	1,392.10	111,196.92	Сургалтын 80,000\$, тусгай зөвшөөрлийн төлбөр 31,196.9\$ -ын үлдэгдэлтэй байсан болно.
6	Энпий	74,467,605.3	1,392.10	53,493.00	39444\$ Эн пи ай ХХК, 14,049\$ Магнай трейд ХХК-ний тусгай зөвшөөрлийн төлбөр болно. Авлагад тусгахдаа ханшийг тухайн өдрийн харилцагч банкны ханшаар тооцож байсан тул бага зэргийн зөрүү гарсан болно.
7	Сансарын геологи	628,729,714.5	1,392.10	451,641.20	Тусгай зөвшөөрлийн төлбөр 181,641.2\$, сургалтын урамшуулал 70,000\$, төлөөлөгчийн газрыг дэмжих 100,000\$, гарын үсгийн урамшуулал 100,000\$ нь тухайн үед өөр дансанд орсон байсныг орж ирээгүй гэж үзэн авлагын дансанд тусгуулсан байна.
8	Гоби энерги	139,210,000.0	1,392.10	100,000.00	Сансарын геологи хайгуул ХХК-ний нэг талбайн гарын үсгийн урамшуулал 100,000\$.
9	МАК	222,736,000.0	1,392.10	160,000.00	Сургалтын урамшуулал 160,000\$ төлөхөөс 100,000\$-ыг 2013.1.25-нд төлсөн.
		12,704,490,653.8		9,126,133.6	

2013 оны жилийн эцэст БХГэрээний дагуу төвлөрүүлэх орлогын дутуу 28,257.7 сая төгрөгийн авлага үүссэнээс:

Петрочайна Дачин Тамсаг компаний ачуулсан түүхий тосны МУ-ын ЗГ-т ногдох орлого 19,4 тэрбум төгрөг, 11 дүгээр сарын дутуу төвлөрүүлснээс 1,6 тэрбум төгрөг, Доншен газрын тос "Монгол" ХХК-ний 4-р улирлын түүхий тосны үлдэгдэл тооцоо 4,3 тэрбум төгрөг, нийт 25,3 тэрбум төгрөгийг авлагаар тооцон бүртгэсэн байна.

2013 онд талбайн дэнчингийн дутуу төлбөрийн 518,313 ам.доллар /857,341.5 мянган төгрөг/-ийг авлагаар бүртгэж, тайланд тусгажээ.

2014 оны жилийн эцэст БХГ-ний дагуу авлагын үлдэгдлийг компани тус бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Урьдчилж тооцсон зардал: ГТБүтээгдэхүүний тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Орон нутгийн төлөөлөгчийн газар ГТБ-ний хүлээн авах болон түгээх үеийн чанарын хяналтын шинжилгээ хийх хүчин чадал бүхий лабораториудыг байгууллахаар

2008 оны улсын төсөвт тусгагдсан 3,350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Үйлдвэр, худалдааны сайдын багцад хувиарласныг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” МУ-ын хуулийн дагуу “Нээлттэй тендер шалгаруулах” журмаар 7 багцтай 1 нээлттэй тендер зарлан зохион байгуулсан.

Багц №1 болох лабораторийн тоног төхөөрөмжийг шалган тохируулан, угсарч суурилуулах гэрээт ажил захиалагчийн лабораторийн байргүйн улмаас хойшлогдсон. Цэцүүх трейд ХХК нь Лабораторийн барилгыг бэлэх болохоор угсарч хүлээлцэхээр гэрээ хийсэн ба тус байгууллагын складанд битүүмжлээтэй байгаа 1,884,952.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээж аваагүйгээс авлага үүссэн байна.

Ажиллагсдын томилолтын урьдчилгаа 2,3 сая төгрөг, Гурван гол ХХК-д түлш халаалтын зардлыг урьдчилж шилжүүлсэн 17,557.3 мянган төгрөг, Цайны газарт 3,8 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэнээр нийт 1,908,610.1 мянган төгрөгийн тооцоо үүссэн байна.

Авлага: 2014 онд Гэрээлэгч компаниудаас 6,350,272.5 мянган төгрөгийн түүхий тосны авлага, АНУ-д суралцаж буй О.Эрхэмбаяр,

Урьдчилж тооцсон тооцоо: 1,884,952.8 мянган төгрөгийн Лабораторийн тоног төхөөрөмж, 63,4 сая төгрөгийн томилолтын урьдчилгаа.

2. Өглөг

	Өглөгийн ангилал	2013 он		2014 он	
		Эхэнд	Эцэст	Эхэнд	Эцэст
1	ТДС-ийн өглөг	63,666.4	9,587.1	9,587.1	-
2	МТ-ХХК / шатахуун/	8,109.2	6,139.4	6,139.4	14,929.5
3	НДаатгалд	167,8	3,350.0	3,350.0	6,248.9
4	Үйлдвэрчний эвлэл	11,8	183,6	183,6	
5	Цалингийн өглөг				98,0
	Нийт дүн	71,955.4	19,260.1	19,260.1	21,276.4

ТДСангийн хөрөнгөөр ажиллагсдад хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, нормын хувцас аваад складанд орлого авахдаа ТДСангийн өглөг дансаар бүртгэж зарцуулсан хэмжээгээр нь өглөгөө бууруулах бичилт хийж байсан ба 2013, 2014 оны үлдэгдэл нь складны үлдэгдэл байна. Аудитын зөвлөмжийн дагуу өглөгийн дансаар дамжуулахгүй болсон байна.

Авлага, өглөгийг жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ирсэн байна.

4.1.3.5 Автомашины ашиглалт, шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал:

1. Засгийн газрын 2007 оны “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” 349 дүгээр тогтоолын 4-д “Хот доторхи ажил, үйлчилгээнд том оврын, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг (100 км-т 16 литрээс их) суудлын автомашин хэрэглэхийг хориглож, энэ талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.” гэсэн заалтыг зөрчиж, 100 км-т 23 литр шатахуун зарцуулдаг 2011 онд тус бүрийг нь 54,5 сая төгрөгөөр худалдаж авсан Chairman маркийн 2 ширхэг суудлын автомашиныг /2015 оны 9 сард/ одоогоор ашиглахгүй байна.

2. Тээврийн хэрэгслийн хувийн хэргийн бүртгэлийг тогтмол дэлгэрэнгүй хөтөлж, засвар үйлчилгээ хийсэн, зарцуулсан сэлбэг хэрэгслийг хүлээлгэн өгсөн, хүлээн авсан жолооч нараар гарын үсгийг нь зуруулж баталгаажуулаагүй байна.

3. Тээврийн хэрэгсэлд сэлбэг, материалыг зарцуулсан, засвар үйлчилгээ хийсэн техникийн комиссийн акт үйлдэхдээ хэний буруугаас болж эвдрэл гэмтэл гарсныг тогтоож, буруутай жолооч нарт хариуцлага тооцож, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-ний 2.9-д “Ажил үүргээ биелүүлэх явцад өөрийн буруугаас эд хөрөнгийн хохирол учруулбал холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн хөрөнгөөр хохирлыг бүрэн арилгана.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал: 2013 оны 06 сард 00-94 УНД дугаартай автомашинд 15,2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан боловч Техникийн комиссын актандаа жолоочид захиргааны арга хэмжээ авах талаар санал оруулсан байна.

2013 оны 10 сард ТДС-аас 9,5 сая төгрөг, 12 сард сургалтын урамшууллын сангаас 23,9 сая төгрөг, нийт 33,4 сая төгрөгийн сэлбэгийн зардал, ТДС-аас 11 сард 869,0 мянган төгрөгийн оношлогооны төлбөр гарсан бөгөөд Ланд-200 маркийн 32-43 УБЧ дугаартай машины жолооч н.Цогбадрах голоор гарахдаа гарам алдаж орсноос машины компьютер шатаж, дээрх засвар үйлчилгээний зардал гарчээ.

4. 2013 онд гадуур тавьсан автомашины гражийн түрээсийн төлбөрт /05-67 УБҮ дугаартай автомашины төлбөрт 2.877,4 мянган төгрөг, 32-43 УНЧ дугаартай автомашины төлбөрт 792,0 мянган төгрөг, 00-94 УНЭ дугаартай автомашины төлбөрт 2,805.0 мянган төгрөг, 96-16 УНА /яамных/ дугаартай автомашины төлбөрт 774,0 мянган төгрөг, 88-97 УНҮ дугаартай автомашины төлбөрт 500,0 мянган төгрөг, 2014 онд 09-77 УНЭ автомашины гаражийн төлбөрт 1,111.5 мянган төгрөг, 05-67 УБҮ автомашины гражийн төлбөрт 1,620.0 мянган төгрөг, нийт 10,479.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч газрын гражид хонож байгаа тээврийн хэрэгслийн бүртгэл хийгдэлгүй ирсэн байна.

5. Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 19 тоот тушаалын 9 дүгээр хавсралтаар баталсан “Резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм”-ыг баримтлаагүй, Аж ахуйн нэгж, байгууллагын эзэд болон эрх баригчид, иргэд нь автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг энэхүү тушаалын 9-р хавсралтаар баталсан “Автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн жишиг норм”-ыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.”, “Резин дугуйны эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг аж ахуйн нэгж, байгууллагын эзэд болон эрх баригчид нь уур амьсгал, авто замын нөхцөлийг харгалзан тогтоосон ашиглалтын бүсээс хамааруулан резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг доорхи хувиар хорогдуулан тооцож болно.” гэж заасны дагуу резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг албан ёсоор нэмэгдүүлж тогтоолгүй резин дугуйг олгож ирсэн байна. Тухайлбал: 2013 оны 9 сард Форд экспедишн /09-77 УНЭ/ автомашиныг 5 дугуйн хамт 125,925.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч, 12 сард дахин 5 ширхэг дугуйг тус машинд зарлагадсан байна.

Дээрх тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд, 5 дугаар хавсралтаар баталсан “Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцөлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцөлүүд” зэргийг үндэслэн Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг тооцож олгож хэвшээгүй байна.

Мөн тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөлгүй, Лексус-570 /05-67 УБҮ/

маркийн автомашинд 30 литр, Лексус-570 /01-31 УНУ/ маркийн автомашинд 30 литр, Форд экспедишн /09-77 УНУ/ маркийн автомашинд 25 литрээр тус тус бодож шатахууныг олгож иржээ.

4.3 Төлөөлөгчийг дэмжин сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын хүрээнд:

Тус газар нь ТДС-ийн хөрөнгийг Төрийн банкин дахь 2400269815 тоот ам.долларын дансанд төвлөрүүлэн, зарцуулж иржээ.

Дансны 2013 оны эхний үлдэгдэл 997,797.18 ам.доллар байсан ба 927,156.77 ам.долларын орлогын гүйлгээ хийгдэж, 1,767,613.4 ам.долларын зарлагын гүйлгээ гарч, оны эцэст 157,340.55 ам.доллар /261,081.5 мянган төгрөг/-ийн үлдэгдэлтэй болсон байна.

4.3.1 Орлого бүрдүүлэлтийн талаар:

БХГэрээний дагуу ТДС-д 1,010.000 ам.доллар төвлөрүүлэхээс 720.000 ам.доллар /1,056,114.6 мянган төгрөг/ төвлөрүүлж биелэлт 52,5 хувьтай байна.

№	Компанийн нэр	2012 оны үлдэгдэл	2013 он		2014 он		Нийт дутуу төлөлт
			Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь	Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь	
1	Петро Матад ХХК	-	5,000	5,000	5,000	-	-5,000
2	Петро Чайна Дачин Тамсаг ХХК	50,000	100,000	150,000	100,000	99,995	-0,005
3	Доншен газрын тос ХХК	-	30,000	30,000	30,000	30,000	-
4	Голдэн Сий петролиум ХХК	35,000	35,000	35,000	35,000	35,000	-35,000
5	Шейман ХХК	-	35,000	-	35,000	-	-70,000
6	DWM Petroleum ХХК /Гоби Энержи Партнерс/	-	200,000	-	200,000	200,000	-200,000
7	Зон Хэн Юу Тиан	-	30,000	30,000	30,000	30,000	-
8	Сентрал Азиан Петролеум корпорейшн лимитед ХХК /Капкорп ХХК/	-	80,000	80,000	80,000	-	-80,000
9	Эн Пи Ай ХХК	-	50,000	50,000	50,000	50,000	-
10	Импайр газ ХХК /М Си Эс ХХК/	-	30,000	30,000	30,000	30,000	-
11	Сансрын геологи хайгуул ХХК	100,000	100,000	200,000	150,000	-	-150,000
12	Шунхлай энержи ХХК	55,000	55,000	-	55,000	110,000	-
13	Алекспро инвестмент ХХК	-	30,000	30,000	30,000	30,000	-
14	Магнайтрейд ХХК	5,000	5,000	5,000	5,000	5,000	-5,000
15	МАК ХХК	-	150,000	-	150,000	50,000	-250,000
16	Вульфпетролиум	-	75,000	75,000	75,000	75,000	-
Нийт дүн		245.000 \$	1,010.000 \$	720.000 \$	1,060.000 \$	744.995 \$	795.005 \$
Өмнөх оны төлөлт				190.000 \$		345.000 \$	
Тухайн оны төлөлт				530.000 \$		399.995 \$	

“Шунхлай энержи” ХХК нь төлөөлөгчийн газрыг дэмжих санд төвлөрүүлэх 55,000\$-ын үлдэгдэлтэй байжээ. УУЯ-ны 2014.11.14-ний өдрийн б-1/118 тоот албан бичигт тус компаний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь 2010.10.07-ны өдрийн УУС-ын тушаалаар гарсан тул 2009 онд БХГ байгуулсан хугацааг тусгай зөвшөөрөл гарсан өдрөөр тооцох талаар чиглэл өгсөн. Тиймээс өглөггүй болж залруулагдсан байна.

4.3.2 ТДС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

ТДС-ийн хөрөнгөнөөс 2013 онд 7 ширхэг 414,802.6 мянган төгрөгийн контейнер, 563,835.6 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 9,500.0 мянган төгрөг сэлбэг запас /капиталжуулсан/, 77,606.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 22,483.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 524,393.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлдсэн байна.

Сангийн яаманд 240,881.9 мянган төгрөг /146.5 мянган ам.доллар/-ыг төвлөрүүлжээ.

Гадаад томилолтод 142,988.9 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн сэлбэгийн зардалд 36,998.5 мянган төгрөг, их засварын зардалд 49,730.0 мянган төгрөг, зураг төсвийн үнэд 14,400.0 мянган төгрөг, “Ард даатгал” ХХК-д тээврийн хэрэгслийн даатгалын төлбөрт 43,512.3 мянган төгрөг, “ЮПРА” ХХК-д газрын тосны салбар дахь бодлого, үйл ажиллагаа, салбарын хууль тогтоомжийг сурталчлах гэрээний төлбөрт 46,300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Байгууллагын ажиллагсаддаа Жи мобайлын гар утас худалдан авч, сунгалтыг хийсэн төлбөрт 11,355.0 мянган төгрөгийг төлжээ.

Үндэсний аудитын газраас “Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын шалгалтаар Хүүгийн орлого төвлөрүүлэх тухай актын төлбөрт 623,759.7 мянган төгрөг, СХД-ийн Татварын хэлтсээс тус газрын 2010-2012 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн шалгалтаар тогтоосон 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 342751 тоот актын төлбөр 47,503.6 мянган төгрөг, нийт 671,263.3 мянган төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.

4.4 Сургалтын сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын хүрээнд:

Тус газар нь Сургалтын сангийн хөрөнгийг Төрийн банкин дахь 2400256294 тоот ам.долларын дансанд төвлөрүүлэн, зарцуулж иржээ.

Дансны 2013 оны эхний үлдэгдэл 75,098.98 ам.доллар байсан ба 1,251,948.1 ам.долларын орлогын гүйлгээ хийгдэж, 1,182,047.0 ам.долларын зарлагын гүйлгээ гарч, оны эцэст 145.000 ам.доллар /240,604.4 мянган төгрөг/-ийн үлдэгдэлтэй болсон байна.

4.4.1 Орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

Сургалтын урамшууллын орлого /ам.доллар/:

Гэрээлэгч компаниуд БХГ-ний дагуу 2013 онд сургалтын урамшууллын санд 1,245.000 ам.доллар төвлөрүүлэхээс 825.000 ам.долларыг төлж, биелэлт 66.3 хувьтай байна. Үүнд:

№	Компанийн нэр	2012 оны үлдэгдэл	2013 он			2014 он		Үлдэгдэл	Нийт зөрүү
			Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь	Үлдэгдэл	Гэрээний дагуу төлөх нь	Гэрээний дагуу төлсөн нь		
1	Петро Матад ХХК	-	30.000	30.000	-	30,000	-	-30,000	-30,000
2	Петро Чайна Дачин Тамсаг ХХК	150,000	150,000	300,000	-	150,000	149,995	-5	-5
3	Доншен газрын тос ХХК	-	60,000	60,000	-	60.000	60.000	-	-
4	Голдэн Сий петролиум ХХК	80.000	80.000	80.000	-80.000	80.000	80.000	-80.000	-80.000
5	Шейман ХХК	-	50,000	-	-50.000	50,000	-	-50,000	-100,000
6	DWM Petroleum ХХК /Гоби Энержи Партнерс/	-	120.000	-	-120.000	120,000	-	-120,000	-240,000
7	Зон Хэн Юу Тиан	-	70.000	70.000	-	70.000	70.000	-	-
8	Сентрал Азиан Петролеум корпорейшн	-	150,000	150,000	-	150,000	-	-150,000	-150,000

	лимитед ХХК /Капкорп ХХК/								
9	Эн Пи Ай ХХК	-	75,000	75,000	-	75,000	75,000	-	-
10	Импайр газ ХХК /М Си Эс ХХК/	-	50,000	50,000	-	50,000	50,000	-	-
11	Сансрын геологи хайгуул ХХК	70,000	70,000	140,000	-	105,000	-	-105,000	-105,000
12	Шунхлай энержи ХХК	95,000	95,000	-	-190,000	95,000	-190,000	-	-
13	Алекспро инвестмент ХХК	-	70,000	70,000	-	70,000	70,000	-	-
14	Магнай Трейд ХХК	10,000	20,000	10,000	-20,000	20,000	20,000	-20,000	-20,000
15	МАК ХХК	80,000	80,000	105,000	-55,000	80,000	55,000	-80,000	-80,000
16	Вульфпетролиум	-	75,000	75,000	-	85,000	85,000	-	-
	Нийт дүн	485,000 \$	1,245,000 \$	1,215,000 \$	-515,000 \$	1,290,000 \$	904,995 \$	-635,005 \$	-805,005 \$
	Өмнөх оны төлөлт			390,000 \$			345,000 \$		
	Тухайн оны төлөлт			825,000 \$			559,995 \$		

“Шунхлай энержи” ХХК нь Сургалтын урамшуулал 95,000\$-ын үлдэгдэлтэй байжээ. УУЯ-ны 2014.11.14-ний өдрийн б-1/118 тоот албан бичигт тус компаний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь 2010.10.07-ны өдрийн УУС-ын тушаалаар гарсан тул 2009 онд БХГ байгуулсан хугацааг тусгай зөвшөөрөл гарсан өдрөөр тооцох талаар чиглэл өгсөн. Тиймээс өглөггүй болж залруулагдсан байна.

2014 жилийн эцсээрхи төлбөрийн үлдэгдэлээс “Магнай Трейд” ХХК, “Петро Матад” ХХК-ууд 2015 онд төлсөн байна.

“Сентрал Азиан Петролеум корпорейшн лимитед” ХХК-ний хувьд 2015.08.03-нд сургалтын урамшууллаас бусад төлбөрийг төлсөн. БХГ-нд сургалтын урамшууллыг хайгуулын эхний 5 жилийн хугацаанд төлнө гэж заасны дагуу сургалтын урамшууллыг төлөөгүй. БХГ-г шинэчлэх үед сургалтын урамшууллыг төлүүлэх талаар дахин ярилцана. гэсэн тайлбарыг өглөө.

“Гоби Энержи Партнерс” ХХК-ийн хувьд ГТГ-ын 2014.04.29-ны 8-529, 2014.10.01-ний 1-1108, 2014.12.08-ний өдрийн 1/1382 албан тоотоор 2014 онд БХГ-ний дагуу төлөгдөх бүх төлбөр, урамшууллыг яаралтай төлөх мэдэгдэл хүргүүлсэн. Хөрөнгө мөнгөний асуудалтай байгаа тул уг асуудлаа шийдвэрлэсний дараа төлөх тухайгаа мэдэгдээд байгаа. юм байна.

“Шейман” ХХК нь хайгуулын эхний 6 жилийн хугацаанд БХГ-ний дагуу төлөх төлбөрүүдээ бүрэн төлсөн ба энэ нь нийт 644.0 мянга гаруй ам.доллар болсон байна.

Хайгуулын хугацаанд батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу ажлаа явуулахад орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй удаа дараа тулгаран хайгуулын ажлыг явуулах боломжгүй нөхцөл байдал үүсч байсан. Иймд гэрээлэгч нь хайгуулын ажлаа бүрэн явуулж чадаагүй тул ажил хийгдээгүй хугацаан дахь төлбөр, урамшууллаа төлөх боломжгүй байгаагаа мэдэгдсэн. Түүнчлэн Хэрлэнгийн хөдөө аралд хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжгүй тохиолдолд БХГ-г дуусгавар болгон хайгуулын хугацаанд оруулсан хөрөнгө оруулалтыг ЗГ-аас нэхэмжлэх тухайгаа мэдэгдсэн албан бичгийг ирүүлээд байна. Үүний дагуу УУЯ-аас чиглэл авахаар албан тоот хүргүүлсэн байна.

“Голдэн Сий петролиум” ХХК-ний хувьд БХГ-ний хугацаа 2013 онд дуусгавар болсон ба БХГ-г дахин сунгах эсэх нь шийдвэрлэгдээгүй байсан учир төлбөрийн авлага үүсгэж байсан. Гэвч БХГ нь цуцлагдах шийдвэр гарах гэж байгаа тул төлбөрүүд хүчингүй болох магадлалтай байна.

“Сансрын геологи хайгуул” ХХК-ийн Цайдам ХХVI, Төхөм Хойд Х талбайнуудын төлбөрийн талаар 2014.03.24-ний 8-359, 2014.07.08-ний 1-775, 2014.10.01 1-1102 тоот албан бичгээр БХГ-ний дагуу төлөгдөх төлбөр урамшууллыг 2014 ондоо багтаан төлөх, төлөөгүй тохиолдолд ГТТХ, БХГ-нд заасны дагуу гэрээг цуцлах талаар мэдэгдээд байна. 2015 онд мөн шаардсан боловч одоог хүртэл төлбөрүүдээ төлөөгүй байна.

“Сансрын геологи хайгуул” ХХК-ийн Номгон IX талбайн хувьд БХГ-ний эрх үүргээ шилжүүлсэн. Төлбөрүүдээ 2015 онд багтаан төлөх тухайгаа мэдэгдсэн.

“Монголын Алт” ХХК-д 2014.07.08-ний 1-774, 2014.10.01-ний 1-1104, 2014.12.02-ний 8-1374 тоот албан бичгээр гэрээнд заасан төлбөр, урамшууллаа төлөх талаар албан бичгүүдийг хүргүүлсэн. Мөн 2014.11.28-ны 5-1346 тоотор 2014 оны төлбөрүүдээ 2014 ондоо багтаан төлөх талаар мэдэгдэл хүргүүлсэн. Гэвч гэрээлэгч төлбөрийг хойшлуулж өгөх талаар 2014 онд хүсэлт ирүүлсэнг ГТГ-аас хүлээн зөвшөөрөөгүй ба төлбөрөө хугацаандаа төлөх талаар мэдэгдсэн хэдий ч төлөөгүй. 2015 онд төлбөрөө график гарган бага багаар төлөх санал ирүүлээд байна. гэсэн тайлбарыг өглөө.

4.4.2 Сургалтын сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

Сургалтын сангийн хөрөнгөнөөс 2013 онд 23,970.6 мянган төгрөг сэлбэг запас /капиталжуулсан/, 70,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 93,970.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлдэж, гадаад томилолтод 73.3 сая төгрөг зарцуулжээ.

Сангийн яаманд 930,902.0 мянган төгрөг /641.3 мянган ам.доллар/-ыг төвлөрүүлсэн байна.

Харин харуул хамгаалалтын төлбөрт 8,5 сая төгрөг, Хан-Уул дүүргийн Өвөр зайсан дахь Бугат ажиллагсдын зуслангийн газрын төлбөрт 2,3 сая төгрөгийг, их засварын зардалд 32,5 сая төгрөг, урвалж бодисын үнэнд 9,8 сая төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.

Үндэсний аудитын газраас 2012 оны “Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын шалгалтаар 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/76 тоот “Гадаад улсуудад явсан аялалын зардалд зориулалт бусаар зарцуулсан” зөрчилд 92,605.7 мянган төгрөгийн акт, 01/77 тоот “Ханшийн зөрүүг нөхөн төлүүлэх тухай” 433,169.7 мянган төгрөгийн акт, 01/78 тоот “Зориулалтын бус зардлыг нөхөн төлүүлэх тухай” 2,948.2 мянган төгрөгийн акт, СХД-ийн Татварын хэлтсээс тус газрын 2010, 2011, 2012 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 342996 тоот актаар 215,327.7 мянган төгрөгийн акт тогтоосон боловч, газрын удирдлагууд гомдол гаргаж, Татварын маргаан таслах зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 67 тоот тогтоолоор 78,948.7 төгрөгийг төлүүлэхээр өөрчлөлт оруулж тогтоосны дагуу шилжүүлж, нийт 607,672.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

5. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилтийн байдал;

1. Газрын тосны газар нь Төлөөлөгчийг дэмжих сан, Сургалтын урамшууллын сан, газрын түрээс, захиргааны үйлчилгээний шимтгэл зэргийг Төрийн банкны харилцах дансанд төвлөрүүлж, төрийн сангийн хяналтгүй зарцуулж байгаа нь Төсвийн тухай

хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д “Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална”, 35 дугаар зүйлийн 35.2-д “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэж заасныг зөрчжээ.

Гэтэл Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д “Гэрээлэгч нь сургалтын болон орон нутаг хөгжүүлэх урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгээс бусад төлбөрийг улсын төсөвт шилжүүлнэ.”, 34.3-д “Сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.” гэж заасан нь Төсвийн тухай хуулийн дээрх заалттай зөрчилдөж байна.

Монгол Улсын “Төсвийн тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.1.5-д “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого”, 47.2-д “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”, 47.3-д “Энэ хуулийн 47.1.2, 47.1.5, 47.1.6-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна.” гэсэн заалтыг зөрчиж, тухайн дансаас зарцуулах хөрөнгийн зардлын төлөвлөлтийг хийж батлуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу зарцуулсан гэж бөөн дүнгээр харуулжээ.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг зөрчиж харьцуулалтын аргаар худалдан авалт хийгээгүй, босго үнээс давсан тохиолдолд сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, 2013 онд 563,835.6 мянган төгрөгийн 6 ширхэг автомашиныг шууд худалдан авалтын аргаар бэлтгэсэн байна. Мөн “Нягт холбоос” ХХК-иар Техник үйлчилгээний төвийн автограж, жолооч нарын өрөөний халаалтын системийн угсралтын 49,5 сая төгрөг, “Синчи Ойл” ХХК-иар Газрын тосны газрын конторын өргөтгөлийн барилгын 246 мкв талбайтай өрөө тасалгааны засал чимэглэлийн 79,5 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ шууд гэрээ хийж, 25,0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Мөн 2008-2012 онд ашиглалтанд орсон нийт 91,758.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, ашиглалтын хугацаа дуусаагүй 6 ширхэг автомашиныг ТӨХ-ны 2013 оны 421 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлж, уг тогтоолоор тайлант онд нийт 632,045.0 мянган төгрөгийн 6 ширхэг автомашиныг, Төрийн өмчийн хорооны 2014 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 246 дугаар тогтоолын дагуу 533,078.3 мянган төгрөгийн балансын үнэтэй 7 ширхэг автомашиныг балансаас балансад шилжүүлж, мөн тогтоолоор 563,835.6 мянган төгрөгийн үнэтэй 6 автомашиныг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төрийн байгууллага, албан газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй”, 14.2.4-д “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах.”, “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-д “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн

талаар Төрийн өмчийн хороонд мэдэгдэж, уг хөрөнгийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгана.” гэж заасныг зөрчиж, ТӨХ-ны зөвшөөрөлгүй 2013 онд төсвийн хөрөнгөөр 330.0 мянган төгрөг, Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр 151,531.7 мянган төгрөг, нийт 151,861.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 2,525.0 мянган төгрөг, БХГ-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр 44,187.4 мянган төгрөг, нийт 46,712.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 414,802.6 мянган төгрөгийн өртөгтэй 7 ширхэг контейнерийг зөвшөөрөлгүй худалдан авсан байна.

2014 онд 667,436.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг БХГ-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр, 162,106.9 мянган төгрөгийн тавилга эд хогшлийг БХГ-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр тус тус худалдан авчээ.

5. Монгол Улсын Санхүү, Эдийн Засгийн Сайдын “Журам батлах тухай” 2001 оны 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 2.7-д “Гадаад оронд албан томилолтоор ажиллах албан хаагчийн албан томилолтын зардлыг манай талаас бүхэлд нь хариуцах бол энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “гадаад оронд болох хурал, зөвлөлгөөн, уулзалт, яармагт оролцох гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар төр, засгийн байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ажилтанд олгох гадаад томилолтын зам-хоног зочид буудлын зардлын хэмжээ”-г баримтлана. Гадаад оронд албан томилолтоор явах унааны зардлыг Улсын Их Хурлын байнгын хороодын дарга, Засгийн газрын гишүүдэд 1-р зэрэглэлийн ангиллаар, бусад албан тушаалтанд энгийн зэрэглэлээр олгоно” гэж заасныг зөрчиж, гадаад томилолтоор явахдаа бизнес ангиллаар зорчиж 2013 онд тус газрын удирдлагууд 4,621.0 мянган төгрөгийг энгийн ангиллын тийзний үнэнээс илүү, зориулалт бусаар зарцуулсан байна.

Дээрх журмын 3.13-д “Гадаад оронд томилолтоор явагчид нь эх орондоо буцаж ирснээс хойш ажлын 7 өдөрт багтаан зардлын гүйцэтгэлийн тайланг гарган, тооцоог хянуулж, үлдэгдлийг байгууллагынхаа харилцах дансанд тушаана” гэсэн заалтыг зөрчиж, 2013 онд тус газрын ажиллагсад хугацаанаасаа өмнө томилолтоос ирсэн боловч, нийт 5,800.9 мянган төгрөгийг буцааж тушаалгүй, зориулалт бусаар зарцуулсан байна. Ажлын 7 хоногийн дотор томилолтын тайлангаа хаадаггүй зөрчил байсаар байна.

Мөн томилолтын хоногийг хянаж олгоогүйгээс 3,099.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. Гадаад томилолтын зардлын гүйцэтгэлд шалгалт хийхэд нийт 13,521.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. /Хавсралт 1/

6. Монгол Улсын Санхүү, Эдийн Засгийн Сайдын “Журам батлах тухай” 2001 оны 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 2.10-д “Гадаад оронд албан томилолтоор ажиллах албан тушаалтанд онгоцны буудлын хураамж унааны боломжоос шалтгаалан зайлшгүй дамжин өнгөрөх улсад хоноглох зардал, визийн хураамжийн зардлыг олгоно. Мөн Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолыг баримтлан эрх бүхий албан тушаалтанд бэлэг дурсгалын зүйлийн зардлыг олгож болно” гэж заажээ.

7. Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4-д “Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 65,0 мянган төгрөг, Монгол Улсын сайд болон аймаг, нийслэлийн засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас тухайн салбар, чиглэлийн шугамаар албан ёсны айлчлал

хийж буй ижил зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 50,0 мянган төгрөг, албан айлчлалын бус үеийн гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 40,0 мянган төгрөгөөс тус тус илүүгүй үнэтэй зүйл байхаар тооцож уг яам, байгууллагын байрны захиргаа буюу санхүү, аж ахуй хариуцсан алба бүртгэл тайланд тусган гаргаж өгөх ажлыг зохион байгуулна”, 2.6-д “Зочин, төлөөлөгчдөд өгөх бэлэг, дурсгалын зүйлс нь соёлын чанартай зүйл байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон түүх, дурсгалын үнэт эдлэл, байгалийн үнэт эрдэнэс баялгийн болон бусад зүйл байж үл болно”, 2.9-д “Дээр дурдсан албан тушаалтнууд гадаад улсад айлчлах, дотоодод томилолтоор ажиллахад шаардагдах бэлэг, дурсгалын зүйлийн хэмжээг энэ бүлэгт заасны нэгэн адил мөрдөнө” гэсэн заалтыг зөрчиж, гадаад томилолтоор явахдаа өндөр үнэтэй, соёлын чанартай бус зүйлсийг авч, хөрөнгөнд үрэлгэн хандсан, мөн Монгол Улсын Санхүү, Эдийн Засгийн Сайдын “Журам батлах тухай” 2001 оны 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 1-д “... гадаадад ажиллах зардлын төлөвлөгөөний төслийг арга хэмжээний нэр, зардлын төрлөөр (унаа, зам хоног-зочид буудлын зардал) нэгтгэн гаргаж” гэж заасныг зөрчиж, оройн зоог, хоолны зардалд гэж 11,506.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Тухайлбал: Газрын тосны газрын даргын 2013 оны №3 тоот тушаалаар А.Эрдэнэпүрэв, О.Эрдэнэбулган, Г.Өлзийбүрэн, Ч.Түмэнбаяр, Э.Халиун нар ОХУ-д явахдаа бэлэг дурсгалд зориулж 550,0 мянган төгрөг,

Уул уурхайн сайдын №146 тоот тушаал, Газрын тосны газрын даргын №97 тоот тушаалаар Л.Раднаасүрэн, Х.Наранхүү, Г.Өлзийбүрэн нар ОХУ явахдаа бэлэг дурсгалд 900,0 мянган төгрөг, оройн зоогт зориулж 3,600.0 мянган төгрөг, /2500 ам.доллар/,

Уул уурхайн сайдын №233, Газрын тосны газрын даргын №209 тоот тушаалаар О.Эрдэнэбулган, Г.Өлзийбүрэн, Б.Ачитсайхан, Д.Болд, Л.Раднаасүрэн нар ОХУ явахдаа бэлэгний зардалд 5,175.0 мянган төгрөг /3000 ам.доллар/, оройн зоогонд 3,450.0 мянган төгрөг /2000 ам.доллар/,

№213 тоот тушаалаар Г.Өлзийбүрэн, А.Энхжаргал, Ц.Амраа, С.Шинэ-Од нар БНХАУ-д томилолтоор явахдаа бэлгэнд 2,571.0 мянган төгрөг /1500 ам.доллар/, хоолонд 4,456.4 мянган төгрөг /2600 ам.доллар/,

Газрын тосны газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Гадаад томилолтоор ажиллуулах тухай 102 тоот тушаалаар ОХУ-д “Роснефть” компанийн удирдлага болон Унгар улсын “МОЛ” группын удирдлагатай уулзах томилолтод Г.Өлзийбүрэн, Х.Наранхүү, Ц.Төгс, ҮАБЗөвлөлийн ахлах референт О.Цэндсүрэн, ЭЗХЯамны ахлах мэргэжилтэн Б.Дашдорж нар оролцохдоо 500 ам.долларыг бэлгэнд зарцуулсан байна.

8. “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчиж, 2013 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” 222 дугаар тушаалаар Сургалтын урт хугацааны гэрээ байгуулж Бээжин хотод ГТосны Их сургуульд суралцаж буй оюутнуудаас

БНХАУ-ын хэмжээнд гадаад оюутнуудын дунд зохион байгуулагдсан хятад хэлний уралдаанд тэргүүн байр эзэлсэн Ч.Золбоо, сургуулийн тэргүүний оюутан болж өндөр амжилт гаргасан Б.Эрдэнэсүх, Г.Тэргэл, Ц.Ариунболд, Оюутны зөвлөлийн зохицуулагчийн урамшуулал Б.Эрдэнэсүх нарт нийт 1,350.0 мянган төгрөгийн урамшууллыг сургалтын сангаас шагнасан боловч сургалт хариуцсан мэргэжилтэн хүлээн авч оюутнуудаар гарын үсэг зуруулаагүй байна.

ГТГ-ын даргын 2013 оны №201 тоот тушаалаар Вьетнам улсад орлогч дарга Ц.Амраа томилолтоор явахдаа 2000 ам.доллар /3,825.4 мянган төгрөг/-ыг төсөвлөж, бэлнээр авч зарцуулсан боловч анхан шатны баримтгүй байна.

Дээрх хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчиж, 2013 оны 6 сард ТДС-ийн харилцахаас “Сэбоцэ” ХХК-луу 5 ширхэг дугуйны үнэнд 1,225.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч сэлбэг хэрэгслийн тайлангаас шаардах хуудасгүйгээр шууд зарлагадсан байна.

2014 оны 01 дүгээр сарын 30-нд Яамны үйл ажиллагаанд нэрээр 3,000.0 мянган төгрөг, 4 сарын 29-нд техник үйлчилгээний төвийн засвар нэрээр 357,5 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

Мөн хуулийн 14 дугаар зүйлийн 14.3.3-д “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх” гэсэн заалтыг зөрчиж төрийн сангийн харилцахаас 10 сард 300,0 мянган төгрөгийг албадан асаагчийн үнэд, ТДС-ийн харилцахаас 2013 оны 4 сард 350,0 мянган төгрөгийг дугуйны үнэд, 5 сард 590,0 мянган төгрөгийг сэлбэгийн үнэд, 12 сард 2,123.7 мянган төгрөгийг сэлбэг материалын үнэнд, 12 сард 1,710.0 мянган төгрөгийг сэлбэгийн үнэнд, Реактив ХХК-луу 9 сард 14,661.6 мянган төгрөг, 12 сард 9,774.4 мянган төгрөг, нийт 24,436.0 мянган төгрөгийг урвалж бодисын үнэд тус тус шилжүүлсэн боловч шууд зардалд бичсэн байна.

9. Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6-д “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед **уг зүйлийг авч зарцуулах хүн** “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.” гэж заасны дагуу сэлбэг хэрэгслийн зарлагыг жолоочийн бичсэн шаардахаар гаргаж байх, хүлээн авсан гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна.

6. Улсын төсвөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагаа, тэдгээрийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн байдал.

Монгол Улсын 2011 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжих Газрын тосны газрын чанарын хяналтын лабораторийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороо, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн

бичгийн даргын “Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай” 2011 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 34 дүгээр тушаалаар байгуулагдсан байна.

Үнэлгээний хороо нь тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Бизнес фокус” ХХК-ийг шалгаруулж, 695,319.8 мянган төгрөгийн төсөвтэй гэрээ байгуулсан байна.

2013 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 108/2013 тоот “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын акт”-аар улсын комисс ашиглалтад хүлээн авжээ.

7. Уул уурхайн сайдын төсвийн багцын Газрын тосны газарт хамааралтай улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл арга хэмжээ, үрсгал зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын тогтолцоо, түүний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх ажлын хүрээнд:

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Орон нутгийн төлөөлөгчийн газар ГТБ-ний хүлээн авах болон түгээх үеийн чанарын хяналтын шинжилгээ хийх хүчин чадал бүхий лабораториудыг байгуулахаар 2008 оны улсын төсөвт тусгагдсан 3.350,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Үйлдвэр, худалдааны сайдын багцад хувиарласныг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” МУ-ын хуулийн дагуу “Нээлттэй тендер шалгаруулах” журмаар 7 багцтай 1 үе шаттай тендер зарлан зохион байгуулсан байна.

Багц №1 болох лабораторийн тоног төхөөрөмжийг шалган тохируулан, угсарч суурилуулах гэрээт ажил, захиалагчийн лабораторийн байргүйн улмаас хойшлогдсон. “Цэцүйх трейд” ХХК нь Лабораторийн барилгыг бэлэн болохоор угсарч хүлээлцэхээр гэрээ хийсэн ба тус байгууллагын складанд битүүмжилсэн 1,884,952.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээж аваагүйгээс авлага үүссэн байна. Үүнийг 2015 оны 1 дүгээр улиралд ажлын хэсгийн комисс хүлээн авчээ.

2014 онд хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ерөнхийлөн захирагчид хүргүүлж, Сайдын тушаалаар батлуулсан ба төсвийн жилийн явцад яаманд асуудал тавьж 3 арга хэмжээг нэмж оруулан өөрчлөлт хийсэн байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 4 Үнэлгээний хороог байгууллагын даргын тушаалаар ажиллуулж, шууд худалдан авалтаар 2, харьцуулалтын аргаар 3, нээлттэй тендер шалгаруулалтаар 7 нийт 12 арга хэмжээг төлөвлөснөөс 11 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй байна. Чулуун дээжний агуулахын барилгын засварын ажил санхүүгийн эх үүсвэртэй холбоотойгоор дутуу биелэлттэй байна.

- Харуул хамгаалалтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерт 4 компани оролцоноос чадавхийн шаардлага хангаж, улмаар хамгийн бага буюу батлагдсан төсвөөс 869.0 мянган төгрөгөөр бага үнийн санал ирүүлсэн “Хос харцага” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулж ажиллаж байна.

- Түлш шатахуун нийлүүлэгчийг тодруулах тендер шалгаруулалтад “Сод монгол” ХХК, “Магнай трейд” ХХК-иуд оролцохоор материалаа ирүүлсэн боловч, чадавхийн шаардлага хангаагүй тул хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу бүх тендерээс татгалзаж, 2014 оны 3 сарын 18-нд дахин зарлаж шалгаруулалт явуулсан. Дахин тендер зарлахад “Магнай трейд” ХХК ганцаар оролцож, 1 литр тутамд 50 төгрөгийн хөнгөлөлт үзүүлэх үнийн саналтайгаар шалгарсан байна.

- Дархан-уул аймгийн төлөөлөгчийн газрын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт 4 компани оролцож 33,148.5 мянган төгрөгийн үнийн саналаар “Их бага авгууш” ХХК шалгарсан байна.

- Байгууллагын хуучин конторын засварт “Ажлын даалгавар”-ыг бэлтгэн, Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн мэргэшсэн төсөвчин Г.Пэлээсүрэнгээр хяналтын төсөв

зохиолгон авч нээлттэй тендер шалгаруулалт зарлахад 6 компани оролцож 102,706.3 мянган төгрөгийн үнийн саналаар “Хан хайрхан” ХХК шалгарсан байна.

- Төрийн өмчийн хорооны 2014 оны 246 тоот тогтоолоор төрийн байгууллагуудад шилжүүлсэн авто машинуудын нөхөн хангалтын ажлыг зохион байгуулахаар нийт 935.0 сая төгрөгийн 7 ширхэг тээврийн хэрэгслийг 3 багц болгон нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах ажлыг гүйцэтгэжээ. Үүнд:

Багц-1: Хөдөө ажлын Ланд круйзер-76 маркийн суудлын автомашин 3 ширхэгийг худалдан авах тендер “Хэт моторс” ХХК 240,000.0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан.

Багц-2: Хөдөө ажлын суудлын автомашин Ланд круйзер-200-тай дүйцэх 3 ширхэг автомашин худалдан авах тендер “Номин моторс” ХХК 390,000.0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан.

Багц-3: Тусгай зориулалтын автобус 1 ширхэгийг худалдан авах тендер “Хьюндай моторс Монгол” ХХК 158,500.0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарсан.

- Байгууллагын хэрэгцээнд тавилга, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар гүйцэтгэж 2014 онд 4 компаниас 184.9 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, зураг төсөв, интерьерийн үйлчилгээ, 7 компаниас төлөөлөгчийн газруудын хэрэгцээнд 43.4 сая төгрөгийн тавилга техник хэрэгслийг худалдан авсан байна.

8. Гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, зээл, хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын тогтолцоо, түүний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх ажлын хүрээнд:

Хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.

9. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолтын байдал:

Тус газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа 2013 онд Ординат ХХК-ийн “Vinnica”, 2014 онд “Юникос” программыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргажээ. Хуучин 2013 оны программаас шаардлагатай журналуудыг хэвлэж авах боломжгүй байсан нь шалгалт хийхэд хүндрэлтэй байлаа.

Шалгалтанд хамрагдах хугацааны анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг Монгол улсын Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар батлагдсан аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу санхүүгийн тайлан, дансны журнал туслах, тодруулгын маягт, анхан шатны маягтыг хөтөлж, санхүүгийн тайланг холбогдох газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Газрын тосны газрын даргын тушаалаар тооллогын комисс томилж, 2013, 2014 онуудад хагас, бүтэн жилээр хөрөнгийн тооллогыг хийж ирсэн байна.

Шалгалтын хугацаанд Лабораторийн хөрөнгөнд хэсэгчилсэн тооллого хийж, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтрийг нээлгэж, зарцуулсан сэлбэг, хэрэгсэл, засвар, үйлчилгээний бүртгэлийг хийлгэлээ.

10. Бусад чиглэлээр:

10.1. Урьд хийгдсэн шалгалтын мөрөөр хийсэн ажил, зөвлөмжийн биелэлттэй танилцах ажлын хүрээнд:

Үндэсний аудитын газраас Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолт хийж буй БНХАУ-ын “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн Тосон-Уул XIX талбайд баригдсан олборлолтын нэгдсэн ил байгууламжийн санхүүгийн зардалд аудит хийж, хөрөнгийн үнэлгээг тогтоож, аудитын зөвлөмж, дүгнэлт гаргах аудитын ажил гүйцэтгүүлэх ажил үйлчилгээг Монгол Улсын ерөнхий аудитор, Газрын тосны газрын дарга нарын хооронд байгуулсан 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 1/17 дугаартай гэрээний дагуу хийж гүйцэтгэжээ.

БНХАУ-ын “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн Тосон-Уул XIX талбайд баригдсан олборлолтын нэгдсэн ил байгууламжийн хөрөнгийн үнэлгээг 89,981,184.2 мянган төгрөгөөр тогтоож, тус компаний өртөг нөхөгдөх зардалд тусгасан байна.

Мөн Газрын тосны газрын 2013, 2014 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГ-аас санхүүгийн аудит хийж, тус газрын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна гэж үзэн “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн байна.

2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГ-аас санхүүгийн аудит хийж, 3 зөвлөмж өгсний Сургалтын болон Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх. гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

11. Шалгалтаар илэрсэн зөрчлийг нэгтгэж үзвэл:

№	Зөрчлийн нэр	Зөрчлийн дүн /мянган төгрөг/	Зөрчлийн утга	Зөрчсөн хууль тогтоомж
1	Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	563,835.6	Харьцуулалтын аргаар худалдан авалт хийгээгүй, босго үнээс давсан тохиолдолд сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, 2013 онд 6 ширхэг автомашиныг шууд худалдан авалтын аргаар бэлтгэсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол
2	Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	49,500.0	2013 онд “Нягт холбоос” ХХК-иар Техник үйлчилгээний төвийн автограж, жолооч нарын өрөөний халаалтын системийн угсралтын ажлыг гүйцэтгүүлэхдээ шууд гэрээ хийж, гүйцэтгүүлсэн байна.	
3	Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	25,000.0	2013 онд “Синчи Ойл” ХХК-иар Газрын тосны газрын конторын өргөтгөлийн барилгын өрөө тасалгааны засал чимэглэлийн 79,5 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ шууд гэрээ хийж, 25,0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.	
4	ТӨХ-ны зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн. 2013 онд 2014 онд	613,376.7 829,543.5	ТӨХ-ны зөвшөөрөлгүй 2013 онд төсвийн хөрөнгөөр 330,0 мянган төгрөг, Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр 151,531.7 мянган төгрөг, нийт 151,861.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 2,525.0 мянган төгрөг, БХГ-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр 44,187.4 мянган төгрөг, нийт 46,712.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 414,802.6 мянган төгрөгийн өртөгтэй 7 ширхэг контейнер, нийт 613,376.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. 2014 онд 667,436.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг БХГ-ний дагуу төвлөрсөн хөрөнгөөр, 162,106.9 мянган төгрөгийн тавилга эд хогшлийг тус тус худалдан авчээ.	Төсвийн тухай хуулийн 16.5.5 дэх заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.4, 14.4, 24.3, 30.2, 30.3 дугаар заалт “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.4
5	Бизнес ангиллаар зорчиж, илүү зардал гаргасан.	4,621.0	Гадаад оронд албан томилолтоор явах унааны зардлыг Улсын Их Хурлын байнгын хороодын дарга, Засгийн газрын гишүүдэд 1-р зэрэглэлийн ангиллаар, бусад албан тушаалтанд энгийн зэрэглэлээр олгоно” гэж заасныг зөрчиж, гадаад томилолтоор явахдаа бизнес ангиллаар зорчиж 2013 онд тус газрын удирдлагууд нийт 4,621.0 мянган төгрөгийг энгийн ангиллын тийзний үнэнээс илүүгээр, зориулалт бусаар зарцуулсан байна.	Санхүү, Эдийн Засгийн Сайдын “Журам батлах тухай” 2001 оны 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын

7	Томилолтын тооцоог журмын дагуу хийгээгүй зориулалт бусаар зарцуулсан.	8,900.4	<p>“Гадаад оронд томиллолтоор явагчид нь эх орондоо буцаж ирснээс хойш ажлын 7 өдөрт багтаан зардлын гүйцэтгэлийн тайланг гарган, тооцоог хянуулж, үлдэгдлийг байгууллагынхаа харилцах дансанд тушаана” гэсэн заалтыг зөрчиж, 2013 онд тус газрын ажиллагсад хугацаанаасаа өмнө томиллолтоос ирсэн боловч, нийт 5,800.9 мянган төгрөгийг буцааж тушаалгүй, зориулалт бусаар зарцуулсан байна. Ажлын 7 хоногийн дотор томилолтын тайлангаа хаадаггүй зөрчил байсаар байна.</p> <p>Мөн томилолтын хоногийг хянаж олгоогүйгээс 3,099.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. Гадаад томилолтын зардлын гүйцэтгэлд шалгалт хийхэд нийт 13,521.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. /Хавсралт 1/</p>	гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 2.7, 3.13.
8	Тогтоосон хэмжээнээс илүү үнэтэй бэлэг, дурсгалын зүйл гардуулсан. Зориулалт бусаар зарцуулсан /хоолны зардалд гэж зарцуулсан/	8,996.0 11,506.4	<p>Гадаадад томиллолтоор явахдаа өндөр үнэтэй, соёлын чанартай бус зүйлсийг авч, хөрөнгөнд үрэлгэн хандсан байна.</p> <p>Тухайлбал: Газрын тосны газрын даргын 2013 оны №3 тоот тушаалаар А.Эрдэнэпүрэв, О.Эрдэнэбулган, Г.Өлзийбүрэн, Ч.Түмэнбаяр, Э.Халиун нар ОХУ-д явахдаа бэлэг дурсгалд 550,0 мянган төгрөг, Уул уурхайн сайдын №146 тоот тушаал, Газрын тосны газрын даргын №97 тоот тушаалаар Л.Раднаасүрэн, Х.Наранхүү, Г.Өлзийбүрэн нар ОХУ явахдаа бэлгэнд 900,0 мянган төгрөг, оройн зоогт зориулж 3,600.0 мянган төгрөг, /2500 ам.доллар/, Уул уурхайн сайдын №233, Газрын тосны газрын даргын №209 тоот тушаалаар О.Эрдэнэбулган, Г.Өлзийбүрэн, Б.Ачитсайхан, Д.Болд, Л.Раднаасүрэн нар ОХУ явахдаа бэлэгний зардалд 5,175.0 мянган төгрөг /3000 ам.доллар/, оройн зоогонд 3,450.0 мянган төгрөг /2000 ам.доллар/, №213 тоот тушаалаар Г.Өлзийбүрэн, А.Энхжаргал, Ц.Амраа, С.Шинэ-Од нар БНХАУ-д томиллолтоор явахдаа бэлгэнд 2,571.0 мянган төгрөг /1500 ам.доллар/, хоолонд 4,456.4 мянган төгрөг /2600 ам.доллар/, Газрын тосны газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Гадаад томиллолтоор ажиллуулах тухай 102 тоот тушаалаар ОХУ-д “Роснефть” компанийн удирдлага болон Унгар улсын “МОЛ” группын удирдлагатай уулзах томиллолтод Г.Өлзийбүрэн, Х.Наранхүү, Ц.Төгс, YAБЗөвлөлийн ахлах референт О.Цэндсүрэн, ЭЗХЯамны ахлах мэргэжилтэн Б.Дашдорж нар оролцохдоо 500 ам.долларыг бэлгэнд зарцуулсан байна.</p>	<p>Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4.</p> <p>Санхүү, Эдийн Засгийн Сайдын “Журам батлах тухай” 2001 оны 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам”</p>
9	Хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан. 2013 онд 2014 онд	35,910.1 3,357.5	<p>Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөнөөс 2013 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” 222 дугаар тушаалаар Сургалтын урт хугацааны гэрээ байгуулж Бээжин хотод ГТосны Их сургуульд суралцаж буй оюутнуудаас БНХАУ-ын хэмжээнд гадаад оюутнуудын дунд зохион байгуулагдсан хятад хэлний уралдаанд тэргүүн байр эзэлсэн Ч.Золбоо, сургуулийн тэргүүний оюутан болж өндөр амжилт гаргасан Б.Эрдэнэсүх, Г.Тэргэл, Ц.Ариунболд, Оюутны зөвлөлийн зохицуулагчийн урамшуулал Б.Эрдэнэсүх нарт нийт 1,350.0 мянган төгрөгийн урамшууллыг сургалтын данснаас шагнасан боловч хүлээн авсан гарын үсэггүй байна.</p> <p>ГТГ-ын даргын 2013 оны №201 тоот тушаалаар Вьетнам улсад орлогч дарга Ц.Амраа томиллолтоор явахдаа 2000 ам.доллар /3,825.4 мянган төгрөг/-ыг төсөвлөж, бэлнээр авч зарцуулсан боловч анхан шатны баримтгүй байна.</p> <p>2013 оны 6 сард ТДС-ийн харилцахаас “Сэбоцэ” ХХК-луу 5 ширхэг дугуйны үнэнд 1,225.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч сэлбэг хэрэгслийн тайлангаас шаардах хуудасгүйгээр шууд зарлагдсан байна.</p> <p>Төрийн сангийн харилцахаас 10 сард 300,0 мянган төгрөгийг албадан асаагчийн үнэд, ТДС-ийн харилцахаас 2013 оны 4 сард 350,0 мянган төгрөгийг дугуйны үнэд, 5 сард 590,0 мянган төгрөгийг сэлбэгийн үнэд, 12 сард 2,123.7 мянган төгрөгийг сэлбэг материалын үнэнд, 12 сард 1,710.0 мянган төгрөгийг сэлбэгийн үнэнд, Реактив ХХК-луу 9 сард 14,661.6 мянган төгрөг, 12 сард 9,774.4 мянган төгрөг, нийт 24,436.0 мянган төгрөгийг урвалж бодисын үнэд тус тус шилжүүлсэн боловч шууд зардалд бичсэн байна.</p> <p>2014 оны 01 сарын 30-нд Яамны үйл ажиллагаанд нэрээр 3,000.0 мянган төгрөг, 4 сарын 29-нд техник үйлчилгээний төвийн засвар нэрээр 357.5 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 14.3.3,</p> <p>Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6,</p>
10	Үйлчилгээний орлогын хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	349,805.4	<p>“Бүтээгдэхүүн хуваах гэрээний Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг зөрчиж, Үндэсний Аудитын газрын 2013 онд “Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн шалгалтаар тогтоосон 2013.10.10-ны өдрийн 01/79 тоот “Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлгүй, Хан-Уул дүүргийн Өвөр зайсан дахь Бугат ажиллагсдын зуслан барихад зарцуулсан” актын төлбөр 207,669.5 мянган төгрөг /128,191.08 ам.доллар/, 2013.10.10-ны өдрийн 01/75 “Тайлан балансад тусгалгүйгээр Хаан банкны дансуудад орлогыг нуун дарагдуулж тайлагнаагүй зөрчил”-д тогтоосон актын төлбөрт 142,135.9 мянган төгрөг /76,627.09 ам.доллар/, нийт 349,805.4 мянган төгрөг /204,818.17 ам.доллар/-ийг шилжүүлж, зориулалт бусаар зарцуулсан байна.</p>	Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалаар батлагдсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээний Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам”
11	Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	671,263.3	<p>Үндэсний аудитын газраас “Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын шалгалтаар Хүүгийн орлого төвлөрүүлэх тухай актын төлбөрт 623,759.7 мянган төгрөг, СХД-ийн Татварын хэлтсээс тус газрын 2010-2012 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн шалгалтаар тогтоосон 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 342751 тоот актын төлбөр 47,503.6 мянган төгрөг, нийт 671,263.3 мянган төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.</p>	Газрын тосны газрын даргын 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 211 дүгээр тушаалаар батлагдсан “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”
	Сургалтын сангийн хөрөнгийг зориулалт бусаар	607,672.3	<p>Үндэсний аудитын газраас 2012 оны “Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын шалгалтаар 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/76 тоот “Гадаад улсуудад явсан аялалын зардалд зориулалт бусаар зарцуулсан” зөрчилд 92,605.7 мянган төгрөгийн акт, 01/77 тоот</p>	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан 182/110

	зарцуулсан		“Ханшийн зөрүүг нөхөн төлүүлэх тухай” 433,169.7 мянган төгрөгийн акт, 01/78 тоот “Зориулалтын бус зардлыг нөхөн төлүүлэх тухай” 2,948.2 мянган төгрөгийн акт, СХД-ийн Татварын хэлтсээс тус газрын 2010, 2011, 2012 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 342996 тоот актаар 215,327.7 мянган төгрөгийн акт тогтоосон боловч, газрын удирдлагууд гомдол гаргаж, Татварын маргаан таслах зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 67 тоот тогтоолоор 78,948.7 төгрөгийг төлүүлэхээр өөрчлөлт оруулж тогтоосны дагуу шилжүүлж, нийт 607,672.3 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	дугаар тушаалаар баталсан “Сургалтын дансны хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам”
12	Зориулалт бусаар зарцуулсан	109,000.0	Засгийн газрын 2007 оны “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” 349 дүгээр тогтоолын 4 дэх заалтыг зөрчиж, 100 км-т 23 литр шатахуун зарцуулдаг 2011 онд тус бүрийг нь 54,5 сая төгрөгөөр худалдаж авсан Chaitman маркийн 2 ширхэг суудлын автомашиныг /2015 оны 9 сард/ одоогоор ашиглахгүй байна.	Засгийн газрын 2007 оны “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” 349 дүгээр тогтоол.
	Зориулалт бусаар зарцуулсан	49,469.0	Тээврийн хэрэгсэлд сэлбэг, материалыг зарцуулсан, засвар үйлчилгээ хийсэн техникийн комиссийн акт үйлдэхдээ хэний буруугаас болж эвдрэл гэмтэл гарсныг тогтоож, буруутай жолооч нарт хариуцлага тооцож, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-ний 2.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: 2013 оны 06 сард 00-94 УНД дугаартай автомашинд 15,2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан боловч Техникийн комиссын актандаа жолоочид захиргааны арга хэмжээ авах талаар санал оруулсан байна. 2013 оны 10 сард ТДС-аас 9,5 сая төгрөг, 12 сард сургалтын урамшууллын сангаас 23,9 сая төгрөг, нийт 33,4 сая төгрөгийн сэлбэгийн зардал, ТДС-аас 11 сард 869,0 мянган төгрөгийн оношлогооны төлбөр гарсан бөгөөд Ланд-200 маркийн 32-43 УБЧ дугаартай машины жолооч голоор гарахдаа гарам алдаж орсноос машины компьютер шатаж, дээрх засвар үйлчилгээний зардал гарчээ.	“Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-ний 2.9,
	Зориулалт бусаар зарцуулсан	19,000.0	2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Шагнах тухай” 89 дүгээр тушаалаар Шатахууны импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд БНХАУ-ын “Чайна ойл” компанитай шатахуун нийлүүлэх гэрээг амжилттай байгуулж, зах зээлд нийлүүлэх ажлыг олон нийтэд сурталчилан зохион байгуулсан 2 албан хаагчийг 15 сая, ГТБХХ-ийг 2 сая, АОХ-ийг 1 сая, УТТХ-ийг 1 сая төгрөгөөр, нийт 19 сая төгрөгөөр шагнасан.	ЗГАЭЗБТХ-ийн 17.1.2 дахь заалтыг зөрчсөн байна.
	Нийт дүн		3,960,757.2 мянган төгрөг	

12. ДҮГНЭЛТ

Аудитын дүнтэй холбогдуулан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1-т зааснаар аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь “Төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тосны хайгуул явуулах талбайг зарлах тухай мэдэгдлийг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэгтэй гэж заасны дагуу Засгийн газар болон Уул уурхайн яамны зүгээс ГТГ-ыг орон нутагтай харилцах, хамтран ажиллахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгад шатахууны үнийг тогтвортой барих бодлогын хүрээнд Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, шатахуун нийлүүлэгч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, шатахуун түгээх станцуудын мэдээ, мэдээллийг тухай бүр гаргуулж авах талаар тусгаж, уялдаа холбоог сайжруулах талаар тусгах;

3. “Тосон-Уул XIX” талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд хуанлийн сард олборлосон гэрээт түүхий тосны өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 50001 баррель буюу түүнээс дээш олборлосон нөхцөлд Засгийн газарт 50%, 1997 оны “БХГ-97”-д өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 20001 баррель буюу түүнээс дээш олборлосон нөхцөлд Засгийн газарт 45%, хайгуулын 2006 оны “Матад ХХ” гэрээнд өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 20001 баррель буюу түүнээс дээш олборлосон нөхцөлд Засгийн газарт 40% ногдохоор заасан байна. Өнөөгийн байдлаар “Тосон-Уул XIX” талбайн өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 10000 орчим баррель, 1997 оны “БХГ-97”-д өдрийн дундаж олборлолтын хэмжээ нь 2700 орчим баррель газрын тос олборлож, экспортолж байгаа нь

Монголын талд ногдох ашигт тосны хэмжээ нь БХГ-д тусгагдсанаар нэмэгдэх боломжгүй зохицуулалт агуулсан байна.

4. “Тосон-Уул XIX” талбайгаас олборлож, экспортолсон тос нь 1997 оны БХГэрээнээс жилд дунджаар 5 дахин их тос экспортолсон ч роялти төлөх нөхцөл гэрээнд тусгагдаагүй нь МУ-д тус гэрээ ашиггүй байна.

5. БХГ-ний хэрэгжилтийг жил бүр дүгнэдэг ба БОНБУ, нөхөн сэргээлтийн талаар байхгүй байна. Байгаль орчны хяналт-шинжилгээг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж, төслөөс байгаль орчинд үзүүлж болох үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн талаарх мэдээлэл, хяналт-шинжилгээний дүнг ил тод байлгаж, орон нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагуудад танилцуулж байх шаардлагатай байна.

6. Газрын тосны газрын даргын “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам” 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 211 дүгээр тушаал нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

7. 1993 оны “Тосон-Уул XIX”, 1996 оны “Тамсаг XXI”, 1997 оны БХГ-нд Монгол Улсын Засгийн газарт төлөхөөр заасан төлбөр, урамшууллыг гэрээний “Д” хавсралтад өртөг нөхөгдөх зардалд оруулан тооцсон нь дээрх БХГ-үүд нь Монгол Улсад ашиггүй байна.

8. Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах 1993, 1997 оны гэрээнүүдэд өдөрт олборлох газрын тосны дундаж хэмжээг 50001 баррелиас давуулсан нөхцөлд Монгол Улсын Засгийн газарт ногдох хувь хэмжээг өсгөж 50 хувьд хүргэх нөхцөл тусгагдсан нь бодит байдал дээр хэрэгжих боломжгүй байгааг бусад БХГ-ний жишигт нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

9. Тосон-Уул XIX талбайн гэрээнд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр буюу роялтийн хэмжээг төлөх тухай заалтыг нэмж оруулах шаардлагатай байна.

10. ГТГ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ, журмын дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамжид тооцоо нийлэх, төлөвлөгөөг гүйцэтгэлтэй нь харьцуулж, үлдэгдлийг тулган баталгаажуулахгүйгээр гэрээлэгч компаниудаас дансанд орж ирсэн мөнгийг орлого гэж бүртгэсэн нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

11. УИХ-ын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.6.3-д “Газрын тосны мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг газрын тосны чиглэлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийг түшиглэн байгуулах, газрын тосны салбарт ажиллах мэргэжилтэй ажилчдын тоог нэмэгдүүлэх”, 3.7.3-д заасан “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжид үндэсний ажиллах хүчнийг авч ажиллуулах тодорхой хувийг тогтоож, бараа, ажил, үйлчилгээг тэргүүн ээлжинд үндэсний аж ахуй нэгж, иргэдээс худалдан авах” бодлогын хүрээнд арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

12. Дээр дурдсан зарим гэрээлэгчдийн хөрөнгө оруулалтад санхүүгийн шалгалт хийгээгүй тул өртөг нөхөгдөх зардлын хэмжээ баталгаажаагүй мөн гүйцэтгэх ажлын

төлөвлөгөө, төсөв батлагдаагүй, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй алтгаанаар гэрээний хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарч ажиллаж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

13. Газрын тосны газрын даргын 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай” 08 дугаар тушаалын 6.3 дахь хэсэг болон 6.9.6 дахь заалт нь “Төрийн албаны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалт, Засгийн газрын “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай” 1995 оны 96 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

14. ГТГ-ын даргын 2013-2015 онуудад батлан гаргасан боловсон хүчин болон үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалууд нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйл, “Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн 8.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2012 оны “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 37 дугаар тогтоол, ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 6, 2010 оны 172 дугаар тогтоолын 2.1.6, 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан “БХГ-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам”-ын 8 болон 9.3 дугаар зүйл, ГТГ-ын даргын 2011 оны “Журам батлах тухай” 211 дүгээр тушаалын дугаар 3 дугаар зүйлийг тус тус зөрчиж, **356,078,494 төгрөгийг** холбогдох хүмүүст олгосон байна.

15. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай сонгон шалгаруулах ажлын хэсэг болон үнэлгээний хороо нь гишүүдийн хувьд харилцан адилгүй тоотой байгуулагддаг, мөн өдрийн 200,000-300,000 төгрөгний урамшуулалтайгаар 3-4 хоног ажилладаг байна.

ҮХС-ын 2008 оны “БХГ-ний Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам батлах тухай” 33 дугаар тушаалын 7.6-д “Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар хавсралтад заагдсан талбай авах захиалгын захиргааны үйлчилгээний шимтгэлээс Гэрээлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг санхүүжүүлнэ. /Зарлан нийтлэх, шаардлагатай материал бэлтгэх, СШЗ, үнэлгээний хороо болон Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдон гарах томилолт, байр, замын зардал, урамшуулал зэрэг бусад зардал орно” гэж заасан нь хэдэн төгрөгөөр урамшуулах тухай нарийвчлан тусгаагүй байна.

16. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Шалгалтын хугацаанд хамрагдсан санхүүгийн үйл ажиллагаанаас харахад тус газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа 2013 онд хангалтгүй байсан боловч 2014 оноос жигдэрч хэвийн явагдаж ирсэн байна.

17. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 2013 онд сургалтын санд 1.225,000 ам.доллар төвлөрүүлэхээс 825,000 ам.доллар буюу биелэлт 67,3 хувьтай, Төлөөлөгчийг дэмжих сангийн үйл ажиллагаанд 1.010,000 ам.доллар төвлөрүүлэхээс 720,000 ам.доллар төвлөрүүлж биелэлт 52,5 хувьтай байгаа нь гэрээний биелэлт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

13. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. “Тосон-Уул XIX” талбайгаас олборлож, экспортолсон тос нь 1997 оны БХГэрээнээс жилд дунджаар 5 дахин их тос экспортолсон ч роялти төлөх нөхцөл гэрээнд тусгагдаагүй байна.

Иймд Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор баталсан БХГ-ны загварын дагуу тус гэрээг яаралтай шинэчилж, роялти буюу байгалийн нөхөн сэргээгдэшгүй нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тусгаж өгөх;

2. “Тамсаг XXI” бүтээгдэхүүн хуваах гэрээний 16.2 дахь зүйлд “Гэрээлэгчийн гаднаас оруулж болох бөгөөд гаалийн татвараас чөлөөлөгдөх зүйлд машин орно” гэсэн нь “Гаалийн тарифын тухай хууль”-ийн 21 дүгээр зүйл, “БНМАУ-ын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 27 дугаар зүйлүүдэд тус тус нийцэхгүй байгаа тул БХГ-ний 16.2 дахь зүйлийг хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх;

3. Газрын тосны газраас Гэрээлэгчдийн хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг тогтоосон хугацаанд ирүүлэхэд анхаарч ажиллах;

4. Газрын тосны газрын даргын 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай” 08 дугаар тушаалыг хууль, тогтоомжийн дагуу шинэчлэн боловсруулах;

5. Агентлагийн дарга нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргах /тушаал батлах/ -ыг анхаарч ажиллах;

6. Газрын тосны газрын даргын “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам” 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 211 дүгээр тушаалыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах;

7. УИХ-ын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын дагуу Газрын тосны мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг газрын тосны чиглэлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийг түшиглэн байгуулах;

8. Монгол Улсын “Төсвийн тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.1.5-д “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого”, 47.2-д “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”, 47.3-д “Энэ хуулийн 47.1.2, 47.1.5, 47.1.6-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна.” гэсэн заалтыг мөрдөж, ТДС-ын данснаас зарцуулах хөрөнгийн зардлын төлөвлөлтийг хийж батлуулан, батлагдсан төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж байх.

9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

10. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

11. Монгол Улсын Санхүү, Эдийн Засгийн Сайдын “Журам батлах тухай” 2001 оны 188 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлыг төлөвлөх, гадаад албан томилолтын зардлын төсвийг зохиох, хянах санхүүжүүлэх, тайлагнах журам зэрэг тогтоол, шийдвэрүүдийг мөрдөж ажиллах.

12. Засгийн газрын 2007 оны “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” 349 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдлөг болгож өндөр өртөгтэй, шатахуун их зарцуулдаг, тансаг хэрэглээний автомашин худалдан авч хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх.

13. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан “Сургалтын хөтөлбөр, журам, үнэмлэхний загвар батлах тухай” 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 161/229 тоот тушаалын дагуу мэргэшсэн жолоочийн эрх аваагүй жолоочид мэргэшсэн жолоочийн нэмэгдэл нэрээр 15 хувийн нэмэгдэл олгож байгааг зогсоох.

14. ”Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

15. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу сургалтын санд төвлөрүүлэх хөрөнгө 66,3 хувьтай, Төлөөлөгчийг дэмжих сангийн үйл ажиллагаанд төвлөрүүлэх хөрөнгө 52,5 хувьтай байгаа нь гэрээний биелэлт хангалтгүй байгаа нь харагдаж байгаа бөгөөд цаашид БХГ-ний биелэлтийг хангаагүй тохиолдолд хариуцлага тооцох заалтыг оруулж өгөх шаардлагатай байна.

ТАНИЛЦУУЛГА ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА

Д.ЖАВХЛАНБОЛД

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

ХШУДАГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ж.АМАРЖАРГАЛ

Х.ЦЭНД-АЮУШ

С.ЦЭЦЭГ-ӨЛЗИЙ

Б.БАЯРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА

Г.ӨЛЗИЙБҮРЭН

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ОЮУН